

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал	15
3.4 Материаллаг байдал	16
3.5.1 Мөнгөн хөрөнгө	16
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт	17
3.5.3 Авлага	17
3.5.4 Урьдчилгаа	18
3.5.5 Бараа материал	19
3.5.6 Нөөцийн бараа	20
3.5.7 Бусад эргэлтийн хөрөнгө	20
3.5.8 Үндсэн хөрөнгө	21
3.5.9 Өр төлбөр	22
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	23
3.5.11 Орлогын данс	23
3.5.12 Зардлын данс	23
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	24
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	26
3.8 Аудитын гол асуудал	26
3.9 Шилэн дансны мэдээлэл	27
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	27
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал	28
4. Аудитын илрүүлэлт	29
Залруулсан алдаа	29
Төлбөрийн акт	30
Албан шаардлага	31
Зөвлөмж	34
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	42

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АШУУС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
БЗС	Боловсролын зээлийн сан
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
МУБИС	Монгол Улсын Боловсролын их сургууль
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ШУТС	Шинжлэх ухаан, технологийн сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
УГЗ	Урьдчилж гарсан зардал
МУИС	Монгол Улсын их сургууль
ТББ	Төрийн бус байгууллага
ХААДС	Хөдөө аж ахуйг дэмжих сан
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
СУИС	Соёл урлагийн их сургууль
ШУА	Шинжлэх ухааны академи
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ГИШҮҮН, БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД Л.ЭНХ-АМГАЛАН
ТАНАА

2021.04.26 № 1330

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

A handwritten signature in black ink, appearing to read 'D. ZANDANBAT', is written over a faint, rectangular red stamp. The signature is fluid and cursive.

Д.ЗАНДАНБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,249,971,854.4	1,086,466,826.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	156,480,373.6	124,453,080.7
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,023,644.8	848,670.8
33	АВЛАГА	287,526,157.4	304,399,395.6
34	УРЬДЧИЛГАА	22,180,849.9	17,741,483.7
35	БАРАА МАТЕРИАЛ	25,868,588.1	15,278,032.8
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	140,874.7
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	756,892,240.7	623,605,288.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,517,028,198.7	1,350,606,961.4
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	100,000.0	100,000.0
37200	Үнэт цаас	100,000.0	100,000.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,516,928,198.7	1,350,506,961.4
39200	Биет хөрөнгө	641,423,691.6	478,164,908.0
39300	Биет бус хөрөнгө	875,504,507.1	872,342,053.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,767,000,053.1	2,437,073,787.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	85,722,145.9	37,353,240.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	85,368,326.3	37,019,662.8
41300	Өглөг	54,167,608.7	10,953,431.6
41400	Урьдчилж орсон орлого	31,200,717.6	26,066,231.1
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	353,819.6	333,577.2
42200	Урт хугацаат зээл	353,819.6	333,577.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,681,277,907.2	2,399,720,547.8
51	Засгийн газрын хувь оролцоо	2,681,277,907.2	2,399,720,547.8
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	253,383,558.3	986,802,315.2
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	39,501,094.1	9,981,967.4
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	2,315,269.4	338,129.3
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	768,113,134.1	78,095.3
51200	Хуримтлагдсан үр дүн	1,291,608,690.4	1,191,567,566.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	326,356,160.9	210,952,474.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,767,000,053.1	2,437,073,787.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,154,774,924.1	2,029,777,192.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	603,097,085.2	529,042,686.1
120	Нийтлэг татварын бус орлого	601,757,682.6	450,001,443.5
121	Хөрөнгийн орлого	108,273.9	-
122	Тусламжийн орлого	1,231,128.6	79,041,242.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,551,677,839.0	1,500,734,505.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,497,502,995.0	1,692,983,548.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,472,182,927.0	1,667,284,965.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	390,735,322.5	330,348,690.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,927,513.3	175,971,811.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,811,295.0	22,839,284.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,765,271.9	10,744,009.7
2104	Хангамж, бараа материалын зардал	8,440,719.4	14,560,550.1
2105	Норматив зардал	1,787,579.0	1,631,244.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,661,988.4	5,073,661.8
2107	Томилолт, зочны зардал	4,180,600.8	1,115,732.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,486,800.2	29,553,949.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,673,554.6	68,858,445.6
211	ХҮҮ	115,777.3	262,163.5
212	ТАТААС	4,282,411.4	4,337,791.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,077,049,415.8	1,332,336,321.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,320,068.0	25,698,583.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	657,271,929.1	336,793,643.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	772,281.2	9,137,259.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	73,370,584.5	284,128,762.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	584,673,625.8	61,802,140.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,823,496,813.0	1,740,390,364.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	255,394,238.8	237,193,077.7
120	Нийтлэг татварын бус орлого	254,140,937.6	234,366,005.0
122	Тусламжийн орлого	1,065,272.7	2,562,114.4
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	188,028.4	264,958.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,568,102,574.2	1,503,197,287.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,480,453,028.1	1,630,110,982.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,480,453,028.1	1,630,110,982.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	388,933,399.6	292,451,971.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,552,723.9	175,047,434.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,854,039.6	13,587,708.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,311,868.1	10,404,792.5
2104	Хангамж, бараа материалын зардал	8,507,500.5	9,001,993.8
2105	Норматив зардал	1,651,167.8	1,635,602.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,608,542.3	5,981,943.5
2107	Томилолт, зочны зардал	4,239,596.8	1,112,917.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,276,025.9	32,259,158.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,931,934.8	43,420,419.4
211	ХҮҮ	12,550.6	8,916.8
212	ТАТААС	4,283,433.3	4,338,162.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,087,223,644.5	1,333,311,931.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	343,043,784.9	110,279,382.6
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	58,876.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	296,451,576.7	130,477,779.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	296,451,576.7	130,477,779.1
2200	Дотоод эх үүсвэрээр	296,451,576.7	130,477,779.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(296,392,700.6)	(130,477,779.1)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(51,155,412.4)	(11,828,896.4)
14	Бусад эх үүсвэр	2,173,469.2	3,186,623.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	51,134,836.2	11,892,960.6
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2,194,045.4	3,122,559.7
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(4,504,328.2)	(32,027,292.9)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	160,984,701.8	156,480,373.6
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	156,480,373.6	124,453,080.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,141,729,985.5	-	2,141,729,985.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(45,127,881.8)	-	(45,127,881.8)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,096,602,103.6	-	2,096,602,103.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(10,848,430.3)	-	(10,848,430.3)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	10,845,258.0	-	10,845,258.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	5,441.6	-	5,441.6
8	Зарласан ногдол ашиг	(91.6)	-	(91.6)
9	Тайлант үеийн үр дүн	584,673,625.8	-	584,673,625.8
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,681,277,907.2	-	2,681,277,907.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(343,313,399.9)	-	(343,313,399.9)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,337,964,507.3	-	2,337,964,507.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(211,207.4)	-	(211,207.4)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	163,023.0	-	163,023.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	408,927.2	-	408,927.2
17	Өмчид гарсан өөрчлөлт	(406,842.3)	-	(406,842.3)
19	Тайлант үеийн үр дүн	61,802,140.2	-	61,802,140.2
20	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,399,720,547.8	-	2,399,720,547.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,738,055,458,000.00	1,564,034,739,906.98	174,020,718,093.02	89.99
УРСГАЛ ЗАРДАЛ	1,393,612,901,700.00	1,291,567,368,218.69	102,045,533,481.31	92.68
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,927,513,800.00	84,309,109,498.79	11,618,404,301.21	87.89
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,641,326,200.00	48,452,117,755.57	1,189,208,444.43	97.60
Үндсэн цалин	35,672,461,500.00	36,050,406,072.30	(377,944,572.30)	101.06
Нэмэгдэл	10,330,105,400.00	9,046,628,808.48	1,283,476,591.52	87.58
Унаа хоолны хөнгөлөлт	2,729,746,400.00	2,420,465,767.85	309,280,632.15	88.67
Урамшуулал	908,012,900.00	933,617,106.94	(25,604,206.94)	102.82
Гэрээт ажлын хөлс	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,407,485,200.00	5,693,364,721.19	714,120,478.81	88.85
Тэтгэврийн даатгал	4,521,999,700.00	4,036,122,063.79	485,877,636.21	89.26
Тэтгэмжийн даатгал	452,771,100.00	412,335,191.52	40,435,908.48	91.07
ҮОМШӨ-ний даатгал	358,039,300.00	327,167,684.40	30,871,615.60	91.38
Ажилгүйдлийн даатгал	96,860,300.00	78,451,339.48	18,408,960.52	80.99
Эрүүл мэндийн даатгал	977,814,800.00	839,288,442.00	138,526,358.00	85.83
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,840,914,800.00	4,337,320,958.39	503,593,841.61	89.60
Гэрэл, цахилгаан	877,603,100.00	840,086,789.40	37,516,310.60	95.73
Түлш, халаалт	1,322,205,900.00	1,140,290,960.32	181,914,939.68	86.24
Цэвэр, бохир ус	253,636,800.00	198,947,689.10	54,689,110.90	78.44
Байрны түрээс	2,387,469,000.00	2,157,995,519.57	229,473,480.43	90.39
Хангамж, бараа материалын зардал	4,461,611,800.00	4,251,320,890.36	210,290,909.64	95.29
Бичиг хэрэг	155,134,800.00	142,204,555.00	12,930,245.00	91.67
Тээвэр, шатахуун	227,962,700.00	203,227,113.00	24,735,587.00	89.15
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	253,180,000.00	231,690,293.77	21,489,706.23	91.51
Ном, хэвлэл	3,507,849,000.00	3,389,270,877.59	118,578,122.41	96.62
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	74,637,800.00	69,423,180.00	5,214,620.00	93.01
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	242,847,500.00	215,504,871.00	27,342,629.00	88.74
Норматив зардал	318,471,000.00	154,410,153.97	164,060,846.03	48.48
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,455,200.00	17,057,870.00	4,397,330.00	79.50
Хоол, хүнс	268,765,500.00	111,509,283.97	157,256,216.03	41.49
Нормын хувцас, зөөлөн эдлэл	28,250,300.00	25,843,000.00	2,407,300.00	91.48
Эд хогшил, урсгал засварын зардал	2,132,173,900.00	1,977,057,528.60	155,116,371.40	92.72
Багаж, техник, хэрэгсэл	1,447,493,900.00	1,418,052,820.00	29,441,080.00	97.97
Тавилга	46,734,000.00	44,990,720.00	1,743,280.00	96.27
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	26,859,400.00	26,297,637.00	561,763.00	97.91
Урсгал засвар	611,086,600.00	487,716,351.60	123,370,248.40	79.81
Томилолт, зочны зардал	183,297,000.00	164,248,326.08	19,048,673.92	89.61
Дотоод албан томилолт	183,297,000.00	164,248,326.08	19,048,673.92	89.61
Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0.00	0.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,598,431,300.00	17,145,089,895.98	8,453,341,404.02	66.98
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,194,173,600.00	16,768,637,760.98	8,425,535,839.02	66.56
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	92,061,200.00	83,840,220.00	8,220,980.00	91.07
Даатгалын үйлчилгээ	26,386,500.00	17,220,320.00	9,166,180.00	65.26
Тээврийн хэрэгслийн татвар	9,135,200.00	7,387,113.00	1,748,087.00	80.86
Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,915,800.00	922,700.00	993,100.00	48.16
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	94,955,800.00	93,631,110.00	1,324,690.00	98.60
Газрын төлбөр	65,138,000.00	60,476,342.00	4,661,658.00	92.84

Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	31,080.00	18,920.00	62.16
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	114,615,200.00	112,943,250.00	1,671,950.00	98.54
Бараа үйлчилгээний бусад зардал	2,343,802,600.00	2,134,179,268.65	209,623,331.35	91.06
Бараа үйлчилгээний бусад зардал	491,006,300.00	446,168,076.00	44,838,224.00	90.87
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,852,796,300.00	1,688,011,192.65	164,785,107.35	91.11
ТАТААС	4,281,091,000.00	4,281,091,000.00	0.00	100.00
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	4,281,091,000.00	4,281,091,000.00	0.00	100.00
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	4,281,091,000.00	4,281,091,000.00	0.00	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,293,404,296,900.00	1,202,977,167,719.90	90,427,129,180.10	93.01
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,230,490,394,200.00	1,150,228,050,200.42	80,262,343,999.58	93.48
Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,230,480,464,900.00	1,150,219,664,751.42	80,260,800,148.58	93.48
Засгийн газрын гадаад шилжүүлэг	9,929,300.00	8,385,449.00	1,543,851.00	84.45
Бусад урсгал шилжүүлэг	62,913,902,700.00	52,749,117,519.48	10,164,785,180.52	83.84
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	148,925,100.00	148,288,500.00	636,600.00	99.57
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,660,575,100.00	6,932,016,946.20	8,728,558,153.80	44.26
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,660,475,500.00	29,383,967,354.28	1,276,508,145.72	95.84
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,275,917,100.00	16,127,747,209.00	148,169,891.00	99.09
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	168,009,900.00	157,097,510.00	10,912,390.00	93.50
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	323,449,181,500.00	261,414,290,907.90	62,034,890,592.10	80.82
Барилга байгууламж	258,094,681,500.00	206,526,481,568.90	51,568,199,931.10	80.02
Их засвар	33,026,500,000.00	24,169,723,262.00	8,856,776,738.00	73.18
Тоног төхөөрөмж	32,328,000,000.00	30,718,086,077.00	1,609,913,923.00	95.02
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	20,993,374,800.00	11,053,080,780.39	9,940,294,019.61	52.65
Эргэж төлөгдөх зээл	20,993,374,800.00	11,053,080,780.39	9,940,294,019.61	52.65
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,738,055,458,000.00	1,564,067,865,867.50	173,987,592,132.50	89.99
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,737,788,519,900.00	1,564,525,612,908.50	173,262,906,991.50	90.03
Улсын төсвөөс санхүүжих	1,737,788,519,900.00	1,564,525,612,908.50	173,262,906,991.50	90.03
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,266,938,100.00	1,753,243,629.20	3,513,694,470.80	33.29
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,231,381,100.00	1,699,611,054.11	3,531,770,045.89	32.49
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,557,000.00	53,632,575.09	(18,075,575.09)	150.84
БУСАД ЭХ ҮҮСВЭР	(5,000,000,000.00)	(2,210,990,670.20)	(2,789,009,329.80)	44.22
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(5,000,000,000.00)	(2,210,990,670.20)	(2,789,009,329.80)	44.22
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	150,953,363.02	(150,953,363.02)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	133,850,041.74	(133,850,041.74)	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	65,128	26,444	38,684	41
БАЙГУУЛЛАГЫН ТОО	71	71	0	100
Төсвийн байгууллага	71	71	0	100
АЖИЛЛАГСДЫН ТОО	3,343	3,379	(36)	101
Удирдах ажилтан	96	104	(8)	108
Гүйцэтгэх ажилтан	2,673	2,681	(8)	100
Үйлчлэх ажилтан	574	594	(20)	103

Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	58,371	19,615	38,756	34
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	52,762	14,708	38,054	28
Төрийн өмчит ЕБС	52,762	14,708	38,054	28
СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	5,180	4,445	735	86
Төрийн өмчит СӨБ байгууллага	5,180	4,445	735	86
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	429	462	(33)	108
Төрийн өмчит МСҮТ	429	462	(33)	108
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	3,343	3,379	(36)	101
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	446	451	(5)	101
Ажлын албаны албан хаагч (АА)	5	5	0	100
СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	234	250	(16)	107
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	1,544	1,514	30	98
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	8	44	(36)	550
Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	300	292	8	97
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	3	3	0	100
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	724	742	(18)	102
Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	0	100
УТҮГ	77	76	1	99

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,651,979,885.82
УРСГАЛ ЗАРДАЛ	24,540,383,853.82
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,587,132,122.48
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,717,206,260.11
Үндсэн цалин	1,504,799,847.30
Нэмэгдэл	31,603,493.00
Унаа хоолны хөнгөлөлт	260,000.00
Урамшуулал	2,177,500.00
Гэрээт ажлын хөлс	1,178,365,419.81
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	301,307,162.64
Тэтгэврийн даатгал	298,505,688.64
Тэтгэмжийн даатгал	700,368.00
ҮОМШӨ-ний даатгал	560,295.00
Ажилгүйдлийн даатгал	140,074.00
Эрүүл мэндийн даатгал	1,400,737.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,449,615,977.74
Гэрэл, цахилгаан	28,891,489.77
Түлш, халаалт	17,679,268.58
Цэвэр, бохир ус	9,922,289.39
Байрны түрээс	1,393,122,930.00
Хангамж, бараа материалын зардал	558,521,097.09
Бичиг хэрэг	113,548,341.00
Тээвэр, шатахуун	220,703,969.34
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,707,618.85
Ном, хэвлэл	70,258,230.40
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,692,735.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	125,610,202.50
Норматив зардал	314,555,788.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	156,886,130.00
Хоол, хүнс	144,953,458.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,716,200.00
Эд хогшил, урсгал засварын зардал	1,363,033,574.55
Багаж, техник, хэрэгсэл	1,062,487,703.55
Тавилга	99,147,150.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,563,130.00
Урсгал засвар	193,835,591.00
Томилолт, зочны зардал	464,134,709.63
Гадаад албан томилолт	38,166,000.00
Дотоод албан томилолт	420,968,709.63
Зочин төлөөлөгч хүлээн авах	5,000,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,185,630,908.86
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,179,243,650.86
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,300,000.00
Даатгалын үйлчилгээ	348,300.00
Тээврийн хэрэгслийн татвар	79,631.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,615,000.00
Газрын төлбөр	1,044,327.00
Бараа үйлчилгээний бусад зардал	5,233,126,643.86
Бараа үйлчилгээний бусад зардал	968,273,755.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,264,852,888.86
ТАТААС	56,700,000.00

Төрийн өмчит байгууллагад олгох татаас	56,700,000.00
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	56,700,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,896,551,731.34
Бусад урсгал шилжүүлэг	271,472,868.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,695,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	263,777,868.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,625,078,863.34
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,625,078,863.34
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	111,596,032.00
Дотоод эх үүсвэрээр	111,596,032.00
Тоног төхөөрөмж	49,000,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	62,596,032.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,289,032,206.43
Нэмэлт санхүүжилтийн орлого	24,289,032,206.43
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,907,225,623.66
ЗГНХ, ЗДН Хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,323,791,999.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,832,021,364.83
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,225,993,218.94
ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(362,647,679.39)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	371,564,908.92
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,917,229.53

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, зарцуулалт, төлбөрийн цахим баримт, хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор Ч.Дашдаваа, Н.Нямсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1а/1678 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Боловсрол, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны эрхэм зорилгыг хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэн боловсрол, шинжлэх ухааны салбарын зөв, оновчтой бодлогыг тодорхойлж, бодитой үр нөлөө үзүүлэх олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар оюуны өндөр боловсролтой, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг, өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✚ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн баталж, тус тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас спорт, соёлын салбарын 374,699.7 сая төгрөгийн хөрөнгөтэй 32 төсөвт байгууллагыг бусад ТЕЗ-д шилжүүлсэн;
- ✚ Засгийн газрын 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн “Боловсрол, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” 51 дүгээр тогтоолоор тус яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, зохион байгуулалтыг тогтоож 11 газар, 4 хэлтэстэй, орон тооны дээд хязгаарыг 110 байхаар баталсан;
- ✚ Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн “Эрүүл мэндийн сургалт, эрдэм шинжилгээний зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай” 98 дугаар тогтоолоор Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа Монгол-Японы эмнэлгийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлсэн;
- ✚ Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоол;
- ✚ Засгийн газрын 2019 оны “Төрийн жинхэнэ зарим албан тушаалын цалингийн сүлжээг тогтоох тухай” 75 дугаар тогтоол;

- ✚ Засгийн газрын Боловсролын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2020 оны 32 дугаар тогтоол;
- ✚ Засгийн газрын 2020 оны 111 дүгээр тогтоолоор “Боловсролын мэдээллийн технологийн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газар шинээр байгуулагдсан;
- ✚ БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны Ажлын хэсгийн төлөвлөгөө /ЗГ-ын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан зарим тоног төхөөрөмж, тавилга, холбогдох бусад баримтыг Соёлын яамны санхүүгийн тайланд шилжүүлэх, хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай 3 дугаар тушаал;

Монгол Улсын Засгийн газар 2020 онд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахалтай холбоотойгоор дараах тогтоолуудыг гаргаж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- ✚ Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай 187;
- ✚ Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 78;
- ✚ Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 114;
- ✚ Коронавируст халдвар Ковид-19 цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай 168;
- ✚ Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 183 дугаар тогтоолууд тус тус байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Өмнөх оны ТЕЗ-ийн аудитаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийн дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.

Мөн 2019 оны А/737 дугаар тушаалаар төрийн өмчит их сургуулийн эрдэмтэн багш нарын бүрэлдэхүүнтэй байгуулагдсан ажлын хэсэг Төрийн өмчит их дээд сургуульд мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулсан бөгөөд салбарын бодлогын баримт бичигт тусгай бүлэг болгон оруулсан байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар тайлант онд төлөвлөгөөт 14, төлөвлөгөөт бус 1 буюу харьяа 15 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж, нийт 1,331.4 сая төгрөгийн зөрчилд 12.2 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 292.6 сая төгрөгийн 8 албан шаардлага, 1,026.6 сая төгрөгийн 105 зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж, зөвлөмжийн биелэлт 84 хувьтай гэж үнэлсэн байна.

Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар 2020 оны шилэн дансанд хяналт шалгалт хийж, харьяа 161 байгууллага, нэгж шилэн дансанд 24,072 мэдээллийг байршуулахаас 18,325 мэдээллийг хугацаанд нь, 3,648 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1,982 мэдээллийг байршуулаагүйд зөвлөмж өгч ажилласан ба биелэлт 92 хувьтай гэж үнэлжээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 1,977,411.5 сая төгрөгийн 1.0 хувь буюу 19,774.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг аудитын хугацаанд санхүүгийн тайланд залруулга хийсэнтэй холбоотой 2020 оны залруулсан санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 1,976,408.7 сая төгрөгийн 1.0 хувь буюу 19,764.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон болно.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 156,480.4 сая, эцсийн үлдэгдэл 124,453.1 сая төгрөг болж 32,027.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт(-)
Кассад байгаа бэлэн мөнгө	25.0	20.9	(4.1)
Банканд байгаа бэлэн мөнгө	140,074.9	80,560.0	(59,514.8)
Хадгаламж	16,380.5	43,872.2	27,491.6
Дүн	156,480.4	124,453.1	(32,027.3)
ТӨҮГ	109,071.8	106,900.0	(2,171.8)
Төсөвт байгууллага	45,952.6	13,508.2	(32,444.5)
Төсөл/Сангууд	1,455.9	4,044.9	2,589.0
Дүн	156,480.4	124,453.1	(32,027.3)

Эх сурвалж: БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Кассын дансанд Хими, хими технологийн хүрээлэнгийн 1.0 сая төгрөг, 3 их сургуулийн 19.9 сая нийт 20.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд барьцаа хөрөнгийн 13,325.6 сая, түрээсийн сурах бичгийн эргэлтийн сангийн 3,857.6 сая, сургалтын төлбөрийн зээлийн эрсдэлийн сангийн 7.4 сая, техник хяналтын 187.2 сая төгрөг, ахмадын сангийн 10.1 сая төгрөг нийт 17,387.9 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, арилжааны 11 банкны 330 харилцах дансанд 12 ТӨҮГ-ын 63,172.1 сая төгрөг байршиж байна.

Барьцаа хөрөнгийн дансны 13,325.6 сая төгрөгийн үлдэгдэлд гүйцэтгэл гараагүй хөрөнгө оруулалтын 32 барилга байгууламжийн ажлын санхүүжилтийг 2019 онд байршуулсан 5,474.8 сая, 4 барилга байгууламжийн 2020 онд байршуулсан 1,162.3 сая, 159 гүйцэтгэгч компанид өгөх барьцаа хөрөнгө 6,307.6 сая нийт 13,212.3 сая төгрөг, Нийслэлийн Боловсрол, соёлын газрын барьцаа хөрөнгө 113.3 сая төгрөг байна.

Арилжааны банкны мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийг байгууллагаар харуулбал, Үүнд:

- ✚ Монгол Улсын их сургууль 75 дансанд 11,624.1 сая;
- ✚ Шинжлэх ухаан, технологийн их сургууль 56 дансанд 21,653.4 сая;
- ✚ Монгол Улсын Боловсролын их сургууль 32 дансанд 13,292.1 сая;
- ✚ Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль 50 дансанд 9,850.9 сая;
- ✚ Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль 9 дансанд 737.4 сая;
- ✚ Улаанбаатар их сургууль 10 дансанд 278.0 сая;
- ✚ Хөдөө аж ахуйн их сургууль 21 дансанд 874.3 сая;
- ✚ Ховд их сургууль 15 дансанд 1,340.1 сая;
- ✚ Соёл урлагийн их сургууль 36 дансанд 2,951.4 сая;
- ✚ Дорнод их сургууль 10 дансанд 32.5 сая;
- ✚ Харьяа 2 ТӨҮГ-ын 8 харилцах дансанд 373.9 сая, 3 хүрээлэнгийн 8 дансанд 164.0 сая төгрөг.

Арилжааны 5 банкны 32 дансанд төрийн өмчит 6 их сургуулийн 3-12 сарын хугацаатай 2.4-13.5 хувийн хүүтэй 43,872.2 сая төгрөгийн хадгаламж байна. Үүнд:

- ✚ Монгол Улсын их сургууль 28,413.2 сая;
- ✚ Монгол Улсын боловсролын их сургууль 6,690.7 сая;
- ✚ Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль 5,199.5 сая;
- ✚ Шинжлэх ухаан технологийн их сургууль 2,108.7 сая;
- ✚ Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль 660.1 сая;
- ✚ Ховд их сургууль 800.0 сая төгрөг.

ТЕЗ-ийн аудитын илрүүлэлт:

- Кассын үлдэгдэл 20.9 сая төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлээгүй /Хими, хими технологийн хүрээлэнгийн 1.1 сая, СУИС 4.8 сая, УБИС, ХААИС 15.0 сая/;
- Харьяа ТӨҮГ-ууд нь Монголбанкны системийн бус арилжааны 5 банкны 15 дансанд 3,707.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй;
- АШУҮИС нь хугацаа дууссан хадгаламжийн дансыг хаагаагүй байна.

Харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:

- ШУА-ийн ерөнхийлөгчийн тушаалаар хүрээлэнгүүдийн захирлын 1 сарын цалинг 1.2 сая төгрөгөөр тогтоож, нийт 275.2 сая төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл урамшил олгосон /Физик технологи, Биологи, Философи, Газарзүй геоэкологи, Одон орон геофизик, Олон улсын харилцаа, Палеонтологи, Түүх угсаатан, Хэл зохиол, Хими, химийн технологийн хүрээлэн/;
- Цалин нэмэгдлийг илүү олгосон, ХХОАТ, НДШ суутгаагүй, НДШ-ийг гүйлгэж тайлагнасан, хөнгөлөлт илүү тооцсон, давхар ажил эрхэлсэн зэрэг нийт 112.4 сая төгрөг /Уул уурхай 55.9 сая, Мал аж ахуйн эрдэм шинжилгээ 1.5 сая, Ургамал, газар тариалан 20.3, Дулаан техник, үйлдвэрлэл экологи 3.8 сая төгрөг, Цөмийн физик судалгаа 9.0 сая, Биологи 7.6 сая, Газарзүй, геоэкологи 14.3 сая, Палеонтологийн хүрээлэн 4.2 сая/;

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 1,023.6 сая, эцсийн үлдэгдэл 848.7 сая төгрөг болж, 174.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт(-)
Үнэт цаас	1,023.6	848.7	(174.9)
Дүн	1,023.6	848.7	(174.9)
Төсөвт байгууллага	1,023.6	848.7	(174.9)
Дүн	1,023.6	848.7	(174.9)

Эх сурвалж: БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат хөрөнгө оруулалт данс нь Боловсролын зээлийн сан 2016-2017 онуудад арилжааны банкаар дамжуулан олгосон хөнгөлөлттэй зээлийг богино хугацаат хөрөнгө оруулалтаар бүртгэсэн ба зээлийн эргэн төлөлт 174.9 сая төгрөгөөр буурсан байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 287,526.2 сая, эцсийн үлдэгдэл 304,399.3 сая төгрөг болж, 16,873.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт
Ажиллагчидтай холбогдсон авлага	385.4	197.0	(188.4)
Төлбөртэй үйлчилгээний авлага	20,370.3	26,832.8	6,462.5
Татаас, санхүүжилтийн авлага	4,600.3	4,257.1	(343.2)
Зээлийн хүүгийн авлага	29.0	39.6	10.6
Дансны авлага /ТӨҮГ/	915.3		(915.3)
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.8	7.1	6.4
Бусад авлага	42,389.8	6,791.0	(35,598.8)
Зээлийн авлага	218,835.4	266,274.8	47,439.4
Дүн	287,526.2	304,399.4	16,873.2
ТӨҮГ	32,831.0	34,319.3	1,488.2
Төсөвт байгууллага	254,445.9	269,931.1	15,485.2
Төсөл/Сангууд	249.3	149.0	(100.3)
Дүн	287,526.2	304,399.3	16,873.2

Эх сурвалж: БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын өсөлт нь БЗС-ийн дотоод, гадаад оюутны зээлийн авлага, өмнөх оны залруулга, ханшийн өөрчлөлтөөр 47,471.8 сая, их сургуулиудын сургалтын төлбөрийн авлага 3,161.5 сая төгрөгөөр нэмэгдэж, хөрөнгө оруулалт, их засварын дансны авлага 11,626.5 сая, соёл, спортын байгууллагуудын авлага 18,955.8 сая, АШУҮС-ийн Капитал банкнаас авах авлага 4,073.3 сая төгрөгөөр тус тус буурснаас голлон шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэлд БЗС-ийн гадаад, дотоод оюутны зээлийн авлага 266,307.0 сая төгрөг, сургалтын төлбөрийн авлага 26,856.0 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлж Сангийн яамнаас буцаан авахаар тооцсон авлага 2,726.7 сая, ШУТС-ийн төслийн 401.5 сая, хадгаламжийн хүүгийн авлага 407.2 сая, байгууллагаас авах авлага 6,453.7 сая, хувь хүнээс авах авлага 1,050.2 сая, ажиллагсдаас авах авлага 197.0 сая төгрөг байна.

Харьяа байгууллагуудад хугацаа хэтэрсэн, он удаан жил болсон 22,994.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна. Үүнд:

- ✚ БЗС-ийн дотоодын их дээд сургуульд хөнгөлөлттэй зээлээр 1995-2020 онд бакалавр, магистрын хөтөлбөрт суралцсан эргэн төлөх журамгүй, төлөгдөх нь тодорхойгүй 14,490 төгсөгчийн 16,744.1 сая;
- ✚ Сургалтын төлбөрийн авлага 2,836.4 сая;
- ✚ МУБИС-ийн дампуурсан Капитал банкнаас авах 2,158.9 сая;
- ✚ ХААИС-ийн 2012 онд үүссэн шүүхийн шийдвэртэй өмнө удирдлагаас авах 467.6 сая, 3 ажилтнаас авах орон сууцны төлбөр 133.7 сая, орон сууц барих урьдчилгаа төлбөрөөс үүссэн шүүхийн шийдвэртэй 93.5 сая, нийт 694.7 сая;
- ✚ ШУТС-ийн 2002-2012 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон 12 төслийн 401.5 сая;
- ✚ Харьяа 4 хүрээлэнгийн 2014-2019 онд үүссэн 159.2 сая төгрөг.

Эдгээр нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, хууль журам хэрэгжихгүйгээс авлагын насжилт нэмэгдэх, найдваргүй авлага өсөх үр дагавартай байна.

ТЕЗ-ийн аудитын илрүүлэлт:

- Улсын төсвөөс санхүүжүүлэхийг зогсоосон тогтмол зардалтай холбоотой АШУҮС 1,527.6 сая төгрөг, ШУТИС 2.8 сая төгрөгийн тогтмол зардлын авлага үүсгэн татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн;
- Нийт 6,411.5 сая төгрөгийн хадгаламжийн хүүгийн орлогыг аккрузал сууриар бүртгээгүй байна /Дорноговь Анагаах ухааны сургууль 199.5 сая, МУБИС 2,643.2 сая, Ховд их сургууль 800.0 сая, ХҮИС 660.1 сая, ШУТИС 2,108.7 сая/;

Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт:

- ШУТС-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт авлагын 53 хувь буюу 546.5 сая төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн, 28 хувь буюу 285.5 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 22,180.8 сая, эцсийн үлдэгдэл 17,741.5 сая төгрөг болж, 4,439.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт
Урьдчилж гарсан зардал	21,025.3	16,204.9	(4,820.4)
Урьдчилгаа тооцоо	1,155.6	1,536.6	381.0
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	539.5	1,040.5	501.0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	498.1	374.1	(123.9)
Цалингийн урьдчилгаа	68.4	63.3	(5.2)
Томилолтын урьдчилгаа	49.6	58.7	9.1
Дүн	22,180.8	17,741.5	(4,439.4)
ТӨҮГ	3,047.1	2,993.4	(53.7)
Төсөвт байгууллага	19,133.7	14,748.0	(4,385.7)
Дүн	22,180.8	17,741.5	(4,439.4)

Эх сурвалж: БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа данс 4,439.4 сая төгрөгөөр буурсан нь ШУТС-ийн төслийн урьдчилж гарсан зардал 5,574.7 сая төгрөгөөр буурснаас голлон шалтгаалсан байна.

Оны эцэст урьдчилгаа дансанд төслийн санхүүжилтийг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн 15,420.1 сая, үндсэн хөрөнгө, бараа материал бэлтгэх 1,382.8 сая, гэрээт ажлын 914.2 сая, бусад 121.9 сая төгрөгийн үлдэгдэл байна. Үүнд:

- ✚ БШУЯ-ны аппарат, хөтөлбөр арга хэмжээний гэрээт ажлын урьдчилгаа 485.3 сая;
- ✚ ШУТС-ийн 2016-2020 онд олгосон 379 төслийн санхүүжилт 12,401.3 сая, бусад гэрээт ажлын урьдчилгаа 45.4 сая төгрөг;
- ✚ Харьяа 13 хүрээлэн ШУТС-аас авсан 59 төслийг төсөл хэрэгжүүлэгчид өгсөн урьдчилгаа 2,132.0 сая;
- ✚ МУБИС-ийн бараа материал бэлтгэх урьдчилгаа 402.6 сая;
- ✚ ШУТИС-ийн хөрөнгө бэлтгэх, төсөл гэрээт ажлын урьдчилгаа 752.5 сая;
- ✚ ХААИС-ийн төсөл, бараа материал, цалин, томилолтын урьдчилгаа 1,009.5 сая;
- ✚ АШУҮИС-ийн Капитал банкнаас авах авлагад тооцож авсан газрыг сургуулийн эзэмшилд шилжүүлж авах 200.0 сая, үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа 232.6 сая нийт 432.6 сая;
- ✚ Харьяа 6 хүрээлэнгүүдийн 177.8 сая төгрөг.

Мөн ШУТС-ийн төслийн хугацаа дуусаж санхүүжүүлэгч болон захиалагчид төслийн үр дүн, санхүүгийн тайланг хүлээлгэж өгөөгүй 145 төслийн 6,549.0 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлын үлдэгдэл байгаа нь хууль, журам хэрэгжихгүй байх, төсөл үр дүнгүй болох, төслийн зарцуулалтад тавих хяналт сул, санхүүгийн тайланд олон жилийн насжилттай урьдчилж гарсан зардал ихсэх муу үр дагавартай байна.

Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт:

- ШУТС-ийн төслийн урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 13,107.5 сая төгрөгийг санхүүгийн программд төслийн нэр, санхүүжилт, гүйцэтгэгч тус бүрээр салгаж бүртгээгүй /Шинжлэх ухаан, технологийн сан 12,401.3 сая, Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэн 500.8 сая Цөмийн физик судалгааны хүрээлэн хэрэгжиж дуусаагүй 4 төслийн нийт 50.8 сая төгрөг/

3.5.5 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 25,868.6 сая, эцсийн үлдэгдэл 15,278.0 сая төгрөг болж, 10,590.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт(-)
Түүхий эд материал	5,000.7	2,856.1	(2,144.7)
Дуусаагүй үйлдвэрлэл	715.1	316.6	(398.5)
Бэлэн бүтээгдэхүүн	708.2	447.7	(260.5)
Хангамжийн материал	19,005.0	11,241.6	(7,763.4)
Мал амьтад	439.6	416.2	(23.4)
Дүн	25,868.6	15,278.0	(10,590.6)
ТӨҮГ	10,497.5	10,476.8	(20.7)
Төсөвт байгууллага	15,371.1	4,801.2	(10,569.9)
Дүн	25,868.6	15,278.0	(10,590.6)

Эх сурвалж: БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал данс 10,590.6 сая төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай. Үүнд:

Нийт нэмэгдсэн 21,211.9 сая төгрөг:

- ✚ Төсвийн хөрөнгөөр нэмэгдсэн 8,469.4 сая,
- ✚ Өөрийн хөрөнгөөр худалдан авсан 8,601.0 сая;
- ✚ Харьяа газрууд БШУЯ-аас шилжүүлэн авсан 2,554.2 сая;
- ✚ Гадаад, дотоод хандиваар 481.5 сая;
- ✚ Малын төл болон нас дэвшилтийн орлогоор 115.6 сая;
- ✚ Тооллогоор илэрсэн, үндсэн хөрөнгөөс шилжүүлсэн, бусад 81.6 сая;
- ✚ Бараа материал данс хооронд шилжүүлсэн 911.6 сая төгрөг.

Нийт хасагдсан 31,875.3 сая төгрөг:

- ✚ Тайлант хугацаанд зарцуулсан 12,709.1 сая;
- ✚ Худалдсан 103.1 сая;
- ✚ Харьяа байгууллага хооронд шилжүүлэн 9,607.1 сая;
- ✚ Соёлын яамны байгууллагуудын бараа материалыг шилжүүлсэн 6,150.1 сая;
- ✚ Акталж данснаас хассан 2,191.3 сая;
- ✚ Данс хооронд шилжүүлсэн 911.6 сая;
- ✚ Үндсэн хөрөнгөд шилжүүлсэн 108.1 сая;
- ✚ Бусад 94.9 сая төгрөг.

Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт:

- Бараа материалыг худалдан авч шууд зардлаар бүртгэсэн, ашиглалтгүй материалууд бүртгэлтэй, төлбөрийн баримтгүй бараа материалыг санхүүгийн тайланд бүртгэсэн, тодруулга тайланд буруу ангилан бүртгэсэн, тооллого хийгээгүй зэрэг нийт 268.0 сая төгрөгийн зөрчлүүд илэрсэн /Ургамал, газар тариалан 8.1 сая, Ургамал хамгаалал, эрдэм шинжилгээ 4.7 сая, Нийгмийн эрүүл мэнд 19.5 сая, Уул уурхай 2.3 сая Физик технологи 231.1 сая, Математик тоон технологийн хүрээлэн 2.3 сая//

3.5.6 Нөөцийн бараа

Нөөцийн бараа эхний үлдэгдэлгүй, эцсийн үлдэгдэл 140.9 сая төгрөг болсон байна.

Хүснэгт №6 Нөөцийн барааны үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт(-)
Бусад нөөц		140.9	140.9
Дүн		140.9	140.9
Төсөвт байгууллага		140.9	140.9
Дүн		140.9	140.9

Эх сурвалж: БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн бараа дансанд харьяа Боловсрол, соёл урлагийн газруудад БШУЯ-аас үнэ төлбөргүй шилжүүлсэн түрээсийн сурах бичгийг бүртгэсэн байна.

3.5.7 Бусад эргэлтийн хөрөнгө

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 756,892.2 сая, эцсийн үлдэгдэл 623,605.3 сая төгрөг болж, 133,286.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7 Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө	756,892.2	623,605.3	(133,286.9)
Төсөвт байгууллага	756,892.2	623,605.3	(133,286.9)
Дүн	756,892.2	623,605.3	(133,286.9)

Эх сурвалж: БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн данс 133,286.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилга байгууламж 224,637.3 сая, тоног төхөөрөмж 24,384.8 сая, гадаад зээлийн эх үүсвэрээр 74,715.2 сая төгрөгөөр нэмэгдэж, ашиглалтад оруулсан барилга байгууламж 258,724.6 сая, барилга байгууламжийг ашиглалтад оруулахад шаардагдах болон харьяа газруудад шилжүүлсэн өгсөн тоног төхөөрөмж 15,609.1 сая, соёл, спортын салбарын дуусаагүй барилга байгууламж, тоног төхөөрөмж шилжүүлсэн 183,744.7 сая төгрөг хасагдсанаас шалтгаалсан байна.

Бусад эргэлтийн хөрөнгөнд дараах үлдэгдэл байна. Үүнд:

- ✚ Боловсролын салбарын дуусаагүй 231 барилга байгууламж 316,152.9 сая;
- ✚ Шинжлэх ухааны салбарын дуусаагүй 3 барилга байгууламж 5,626.8 сая;
- ✚ Эрх шилжүүлэн хэрэгжүүлж байгаа 149 барилга байгууламж 215,264.6 сая;
- ✚ Боловсролын салбарын 387 нэр төрлийн 98,926 ширхэг тоног төхөөрөмж, тавилга эд хогшил 10,771.9 сая;
- ✚ Шинжлэх ухааны салбарын 2 нэр төрлийн 10 ширхэг 19.8 сая нийт 547,836.0 сая;
- ✚ Гадаад зээлийн эх үүсвэрээр нэмэгдсэн 74,715.2 сая төгрөг.

ТЕЗ-ийн аудитын илрүүлэлт:

- Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгө дансанд 2015-2019 онуудад ашиглалтад орох байсан боловч улсын төсвийн санхүүжилт зогссон, гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ биелүүлээгүй, шүүхийн маргаантай гэх мэт 137,869.5 сая төгрөгийн дуусаагүй хөрөнгө оруулалтын 107 ажлын үлдэгдэл байна.

3.5.8 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,687,926.8 сая, эцсийн үлдэгдэл 1,519,465.6 сая төгрөг болж, 168,461.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №8 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт(-)
Биет хөрөнгө	807,291.3	640,413.7	(166,877.6)
Барилга, байгууламж, орон сууц	456,254.1	374,190.8	(82,063.3)
Авто-тээврийн хэрэгсэл	12,117.7	11,271.3	(846.4)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	168,816.9	163,405.0	(5,411.9)
Тавилга, аж ахуйн эд хогшил	42,189.2	38,963.2	(3,226.0)
Зам, гүүрийн байгууламж	1,828.4	1,811.9	(16.5)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	72,610.8	2,257.7	(70,353.1)
Бусад үндсэн хөрөнгө	8,206.9	4,779.5	(3,427.4)
Дуусаагүй барилга, байгууламж	29,174.4	31,847.6	2,673.2
Ном	16,093.0	11,886.7	(4,206.3)
Биет бус хөрөнгө	880,635.5	879,051.9	(1,583.6)
Програм хангамж	11,436.9	14,842.4	3,405.5
Бусад биет бус хөрөнгө	869,198.6	864,209.5	(4,989.1)
Дүн	1,687,926.8	1,519,465.6	(168,461.2)
ТӨҮГ	595,948.0	542,167.8	(53,780.2)
Төсөвт байгууллага	1,091,978.8	977,297.8	(114,681.0)
Дүн	1,687,926.8	1,519,465.6	(168,461.2)

Эх сурвалж: БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны 168,461.2 сая төгрөгийн өөрчлөлт дараах шалтгаантай. Үүнд:

Нийт нэмэгдсэн 54,595.8 сая төгрөг:

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,819.8 сая;
- Өөрийн хөрөнгөөр худалдан авсан 14,631.5 сая;
- Өмнөх онд төлбөрийг нь урьдчилж шилжүүлснээс нэмэгдсэн 1,197.0 сая;
- АШУУС Капитал банкнаас авах авлагад эмнэлэг шилжүүлэн авсан 3,987.3 сая;
- БМТТ УТҮГ нь Дээд боловсролын шинэчлэл төслөөс шилжүүлэн авсан программ хангамж 3,444.2 сая;
- Харьяа 51 байгууллага компьютер, техник хэрэгсэл, бусад тусгай зориулалтын тоног төхөөрөмж БШУЯ-аас шилжүүлэн авсан 2,659.3 сая;
- Шинэ эхлэл олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит сургуулийн 1,136.7 сая;
- Хандив гадаад 4,902.5 сая, дотоод хандив 2,076.3 сая;
- Бусад ТЕЗ-ийн харьяа байгууллагуудаас 737.3 сая;
- Харьяа байгууллага хооронд шилжүүлэн авсан 12,378.3 сая;
- Хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээгээр 4,467.3 сая;
- Тооллогоор илэрсэн, бараа материалаас шилжүүлсэн, бусад 1,158.3 сая;

Нийт хасагдсан 223,056.9 сая төгрөг:

- Тайлант хугацаанд худалдсан 53.8 сая;
- Акталж данснаас хассан 10,921.3 сая;
- Харьяа байгууллага хооронд шилжүүлэн 12,417.3 сая;
- Соёл, спортын байгууллагуудын үндсэн хөрөнгийг шилжүүлсэн 190,769.8 сая;
- Хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх зорилгоор данснаас хассан 8,135.2 сая;
- Бусад байгууллагуудад шилжүүлсэн 386.3 сая;
- Бусад 373.2 сая төгрөг байна.

ТЕЗ-ийн аудитын илрүүлэлт:

- Харьяа байгууллагуудын зам гүүрний барилга байгууламжийн дансанд монгол гэр, контейнер, хаалга, навчит мод, гэрийн буурь, цэвэр бохир усны шугам гэх мэт 651.1 сая төгрөг бүртгэлтэй байна.
- Дуусаагүй барилга дансанд 2012-2017 онд үүссэн 2,098.4 сая төгрөг бүртгэлтэй байна. /МУИС-160.0 сая, ШУТИС-366.4 сая, ХААИС-1,571.9 сая төгрөг/

Харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:

- Өмнөх зөвлөмжөөр өгсөн биет бус хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй, худалдан авсан хөрөнгө дутуу бүртгэсэн, карт хөтлөөгүй, суудлын автомашин худалдан авахдаа ТБӨХБАҮХА тухай хуулийг мөрдөөгүй, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг санхүүгийн программд илүү тооцсон, анхны өртгөө нөхсөн хөрөнгө бүртгэлтэй нийт 2,333.7 сая төгрөг /БЗС 153.5 сая, БҮТ 347.6 сая, Ургамал, газар тариалан 24.8 сая, Мал аж ахуйн эрдэм шинжилгээ 59.6 сая, Уламжлалт анагаах ухаан 418.0 сая, Биологи 511.3 сая, Палеонтологи 15.0 сая, Математик, тоон технологи 4.3 сая, Газарзүй, геоэкологи 724.4 Хими, хими технологи 75.2 сая/

3.5.9 Өр төлбөр

Өр төлбөрийн эхний үлдэгдэл 85,722.1 сая, эцсийн үлдэгдэл 37,352.6 сая төгрөг болж, 48,369.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №9 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт(-)
Өглөг	54,167.6	10,953.4	(43,214.2)
Урьдчилж орсон орлого	31,200.7	26,065.6	(5,135.2)
Урт хугацаат зээл	353.8	333.6	(20.2)
Дүн	85,722.1	37,352.6	(48,369.6)
ТӨҮГ	36,338.1	29,906.8	(6,431.3)
Төсөвт байгууллага	49,165.5	7,280.4	(41,885.1)
Төсөл/Сангууд	218.6	165.3	(53.3)
Дүн	85,722.1	37,352.5	(48,369.6)

Эх сурвалж: БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн данс 48,369.6 сая төгрөгөөр буурсан нь барьцаа хөрөнгийн дансанд байршиж байсан хөрөнгө оруулалтын ажлын өглөг, барьцаа хөрөнгө 39,236.2 сая, их сургуулиудын урьдчилж орсон орлого 5,377.8 сая төгрөгөөр буурч, соёл, спортын байгууллагын өглөг 3,139.8 сая төгрөгөөр хасагдсанаас голлон шалтгаалсан байна.

Өр төлбөрийн 37,450.1 сая төгрөгийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

- ✚ БШУЯ-ны улсын төсвийн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн 6,575.1 сая
- ✚ Сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлого 23,526.9 сая;
- ✚ Бусад урьдчилж орсон орлого 2,636.1 сая;
- ✚ Бусад байгууллагад өгөх өглөг 2,253.8 сая;
- ✚ ТӨҮГ-уудын татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 86.7 сая;
- ✚ Харьяа байгууллагуудын төслийн зээлийн өглөг 333.6 сая,
- ✚ Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг 1,392.2 сая;
- ✚ Ажиллагсадтай холбоотой өглөг 537.1 сая;
- ✚ Дансны өглөг 108.7 сая төгрөг.

Харьяа газруудын аудитын илрүүлэлт:

- ШУТС-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн 37.5 хувь буюу 136.2 сая төгрөгийн өглөг хугацаа хэтэрсэн, 35 хувь буюу 128.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Дулаан техник, үйлдвэрлэл экологийн хүрээлэн 187.0 сая төгрөгийг тооцоо нийлсэн акт үйлдэн хүлээн зөвшөөрсөн боловч 93.0 сая төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй;
- Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэн санхүүгийн тайланд өглөгийг 9.5 сая төгрөгөөр дутуу тусгасан байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,681,277.9 сая, эцсийн үлдэгдэл 2,399,720.5 сая төгрөг болж, 281,557.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 10. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт(-)
Засгийн газрын оруулсан капитал	253,383.6	986,802.3	733,418.7
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	39,501.1	9,982.0	(29,519.1)
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	2,315.3	338.1	(1,977.2)
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	768,113.1	78.1	(768,035.0)
Хуримтлагдсан үр дүн	1,291,608.7	1,191,567.5	(100,041.2)
Өмнөх үеийн үр дүн	706,935.1	1,129,765.4	422,830.3
Тайлант үеийн үр дүн	584,673.6	61,802.1	(522,871.5)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	326,356.2	210,952.5	(115,403.7)
Дүн	2,681,277.9	2,399,720.5	(281,557.4)

Эх сурвалж: БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ЗГХО дансны үлдэгдлийн өөрчлөлт дараах шалтгаантай байна. Үүнд:

- Соёл, спортын байгууллагуудын санхүүгийн тайланг шилжүүлснээр төрийн өмч, НТК, Эздийн өмчийн бусад хэсэг 768,035.0 сая, өмнөх үеийн үр дүн 422,830.3 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Харьяа 11 байгууллага 451.3 сая төгрөгөөр өмнөх үеийн үр дүнг нэмэгдүүлсэн;
- Акталсан хөрөнгийн дахин үнэлгээ 115.4 сая төгрөгөөр хасагдсан;
- Гадаад зээлийн эх үүсвэрээр нэмэгдсэн 74,715.2 сая төгрөгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэснээс голлон шалтгаалж тайлангийн үр дүн 61,802.1 сая төгрөг тайлагнагдсан байна

Аудитын илрүүлэлт:

- Биологийн хүрээлэнгийн санхүүгийн тайланд тусгагдсан төрийн өмчийн дүн нь улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан дүрмийн сангийн хэмжээнээс 238.5 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан.

3.5.11 Орлогын данс

Орлого үр дүнгийн тайлангаар улсын төсвийн санхүүжилтээр урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд 1,388,759.6 сая, хөрөнгийн санхүүжилтэд 89,979.4 сая, тусгай сангаас 1,994.3 сая, тусгай зориулалтын шилжүүлгээс 1,286.1 сая, нэмэлт санхүүжилтээр 16,181.5 сая, гадаад дотоод хандив тусламжийн орлого 79,041.8 сая, үндсэн үйл ажиллагааны орлого 170,376.5 сая, туслах үйл ажиллагааны орлого 64,048.2 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 195,926.7 сая, бусад эх үүсвэрээс санхүүжсэн 4,060.9 сая, түрээсийн орлого 292.1 сая, бусад орлого 9,724.6 сая, ТЭЗ хооронд хийсэн санхүүжилт 186.0 сая, ЭМД-аас санхүүжих 1,975.6 сая, хүүг, торгуулийн орлого 5,540.4, ханшийн зөрүүгийн олз 9,002.5 сая, үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз 134.8 сая нийт 2,038,210.8 сая төгрөгийн орлогыг тайлагнасан байна.

3.5.12 Зардлын данс

Орлого үр дүнгийн тайлангаар цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 198,811.9 сая, байр ашиглалтын зардалд 10,744.0 сая, хангамж, норматив, эд хогшлын зардалд 21,245.5 сая, томилолтын зардалд 1,115.7 сая, бараа үйлчилгээ, бусдаар гүйцэтгүүлсэн ажлын 24,456.4 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 68,858.4 сая, хүүгийн зардалд 262.1 сая, төрийн өмчит байгууллагад олгох татаас 4,337.8 сая, тусгай зориулалтын шилжүүлэг 1,158,219.7 сая, бусад урсгал шилжүүлэг 72,051.5 сая, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 16,047.7 сая, хөрөнгийн зардалд 25,601.0 сая, төвлөрүүлэх шилжүүлэг 86,002.0, үйл ажиллагааны бус зардал 283,522.6 сая, нийт 1,976,408.7 сая төгрөгийг тайлагнасан байна.

ТЭЗ-ийн аудитын илрүүлэлт:

- БШУЯ-ны худалдан авалтаас 306 ААН-ийн 74,985.8 сая төгрөг цахим төлбөрийн баримтаар нотлогдоогүй;

- Хөтөлбөр арга хэмжээний зардлаас буцалтгүй тусламж, шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговор, яамны гэрээт ажилтнуудын цалин, ахмадын арга хэмжээ, гадаад томилолтын зардалд нийт 200.2 сая төгрөг зарцуулсан байна.

Харьяа газруудын аудитын илрүүлэлт:

- Нийт 662.0 сая төгрөгийн худалдан авалт цахим төлбөрийн баримтаар нотлогдоогүй /Боловсролын үнэлгээний төв 387.9 сая, Шинжлэх ухаан, технологийн сан 82.5 сая, Цөмийн физик 10.2 сая, Дулаан техник, үйлдвэрлэл экологи 1.8 сая, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн 18.0 сая, Ургамал хамгаалал эрдэм шинжилгээ 5.8 сая, Мал аж ахуй эрдэм шинжилгээ 50.6 сая, Анагаах ухааны хүрээлэн 8.7 сая, Палеонтологи 7.1 сая, Хэл зохиол 5.5 сая, Физик технологи 46.7 сая, Түүх угсаатны зүйн 3.2 сая, Олон улсын харилцааны хүрээлэн 2.6 сая, Археологи 6.6 сая, Геологи 0.5 сая, Одон орон геофизик, Биологи 148.1, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн 15.2 сая төгрөг/;
- Шатахууны зарцуулалтын замын хуудсыг үндэслэн тооцоо бодоогүй, лимит хэтрүүлж шатахууны зардлыг 112.3 сая төгрөгөөр илүү олгосон /Уламжлалт анагаах ухаан 85.7 сая, Мал аж ахуй, эрдэм шинжилгээ 17.1 сая төгрөгийн Газарзүй, геоэкологи 9.1 сая, Палеонтологийн хүрээлэн 0.4 сая/;
- Дулаан техник, үйлдвэрлэл экологийн хүрээлэн түрээсийн гэрээний төлбөрөөс 0.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй; ажил гүйцэтгэсэн гэрээг дутуу дүгнэж 65.0 сая төгрөгийг зардлаар бүртгэсэн;
- Палеонтологийн хүрээлэн "Эйр транс" ХХК-аас 10.3 сая төгрөгийн нислэгийн тасалбарын үнийг буцаан аваагүй байна;
- Ургамал хамгаалал, эрдэм шинжилгээний хүрээлэн өмгөөллийн үйлчилгээний хөлсөнд 2.5 сая төгрөгийг зарцуулж зориулалт бус зардал гаргасан;
- Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэн томилолтын хуудасгүй зардал 28.1 сая төгрөг.
- ШУТС-ийн баталсан бүтцээр 3 хэлтсийн нийт 24 орон тооноос санхүү, төлөвлөлтийн хэлтсийн 7 ажилтан нь нийт ажилтнуудын 30 хувийг эзэлж орон тоо, бүтэц оновчтой бус, харьяа 3 хүрээлэн батлагдсан орон тоог 26-аар хэтрүүлэн ажилласан;

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагч 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 4,865,612.1 сая төгрөгөөр тус тооцон төлөвлөж, Төсөв санхүү эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Хүргүүлсэн төсвийн төслөөс 2,642,650.2 сая төгрөгөөр бууруулж 2,222,961.9 сая төгрөгөөр баталсан байна.

Мөн тодотгосон төсвөөр нийт зардлыг 484,906.4 сая төгрөгөөр бууруулсан нь Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 2020 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, хөрөнгийн зардал, тусгай зориулалтын шилжүүлэг, оюутны хөгжлийн зээл, урсгал зардлууд буурсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус сангийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөр, 21 арга хэмжээнд зориулан урсгал зардалд 1,393,612.9 сая, хөрөнгийн зардалд 323,449.2 сая, оюутны хөгжлийн зээлд 20,993.4 сая нийт 1,738,055.5 сая төгрөгийг зарцуулахаар улсын төсвөөс 1,737,788.6 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 5,231.4 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 35.5 сая төгрөг санхүүжүүлэхээр батлагджээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал санхүүжилтээр 1,374,973.3 сая, хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 260,628.2 сая, оюутны хөгжлийн зээлийн санхүүжилтээр 13,786.2 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1,753.2 сая төгрөг, нийт 1,651,140.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн.

Тайлант онд урсгал зардалд нийт 1,291,567.4 сая төгрөг зарцуулсан. Үүнд:

- ✚ Бараа үйлчилгээний урсгал зардалд 84,309.1 сая;
- ✚ Төрийн өмчийн байгууллагад олгох татаас 4,281.1 сая;
- ✚ Тусгай зориулалтын шилжүүлэг (ЕБС, СӨБ)-ийн зардалд 1,150,219.8 сая;

- ✚ Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал 148.3 сая;
- ✚ Засгийн газрын гадаад шилжүүлэг 8.3 сая;
- ✚ Боловсролын зээлийн оюутны тэтгэлэг 6,932.1 сая;
- ✚ Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 29,383.9
- ✚ Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 16,127.7 сая;
- ✚ Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 157.1 сая.

Төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлсэн 89,961.4 сая, 21 аймаг, нийслэлд эрх шилжүүлж 170,666.8 сая, нийт 260,628.2 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын зардал зарцуулсан.

Мөн тайлант оны эргэж төлөгдөх цэвэр зээлд 5,000.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2,211.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 13,264.1 сая төгрөгийг зарцуулж, оюутны хөгжлийн зээл цэвэр дүнгээр 11,053.0 сая төгрөгөөр нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнагдсан.

Төсвийн гүйцэтгэлээр нийт 1,563,248.6 сая төгрөгийг зарцуулж дутуу зарцуулсан 88,121.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Оны эцэст нийт татан төвлөрүүлсэн 88,321.4 сая төгрөгийн санхүүжилтээс хасагдах 65,139.8 сая төгрөг, тусгай зориулалтын хэмнэлтээс төвлөрүүлсэн 20,509.0 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 261.5 сая нийт 86,000.7 сая төгрөг, БЗС-ийн эргэж төлөгдөх цэвэр зээл 2,211.0 сая, нэр данс зөрүүгээс буцаан орж ирснээс төвлөрүүлсэн 200.1 сая төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлээс дутуу зарцуулсан 174,806.8 сая төгрөг буюу 89.9 хувьтай байгаа нь улсын төсвөөс урсгал зардлыг 25,579.7 сая, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг 62,820.9 сая, дутуу санхүүжүүлсэн, зарцуулаагүй 85,910.3 сая төгрөгийг оны эцэст буцаан төвлөрүүлснээс голлон шалтгаалсан ба дараах материаллаг дүнтэй дутуу зарцуулалт гарсан зардлууд байна. Үүнд:

- ✚ Тусгай зориулалтын шилжүүлэг 80,262.3 сая;
- ✚ Бусад урсгал шилжүүлэг 10,164.8 сая;
- ✚ Оюутны хөгжлийн зээл 9,940.3 сая;
- ✚ Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,903.3 сая;
- ✚ Байр ашиглалттай холбоотой зардал 503.6 сая;
- ✚ Хангамжийн материалын зардал 210.3 сая;
- ✚ Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 8,453.3 сая төгрөг.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 323,449.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 255,265.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, 5,259.7 сая төгрөгийг барьцаа дансанд, 102.8 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гадаад төсөл хөтөлбөрийн санхүүжүүлэгч 55 байгууллагаас 4,884.4 сая, дотоод хандив 23.2 сая, Засгийн газрын нөөц хөрөнгөөс 406.8 сая, Орон нутгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилагдсан 917.2 сая, дээд шатны төсвийн захирагчаас 7,832.0 сая, бусад ТЕЗ-аас хуваарилсан 5,159.3 сая, Аймаг, нийслэлийн төсөвт байгууллагаас хуваарилсан эх үүсвэрээс 501.4 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,793.8 сая, тухайн жилд тушаалаар олгосон давсан орлого 133.8 сая, нийт 24,651.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 3,018.5 сая, байр ашиглалтын зардалд 1,449.6 сая, хангамжийн материалд 558.5 сая, норматив зардалд 314.5 сая, томилолт эд хогшил урсгал засварын зардалд 1,363.3 сая, томилолтын зардалд 464.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, бараа үйлчилгээний бусад зардалд 9,185.6 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 5,561.2 сая, хөрөнгийн зардалд 111.6 сая нийт 22,026.8 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,625.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

Үүнээс 98.6 сая төгрөгийг улсын төсвийн орлогод тооцуулж, 2,526.5 сая төгрөгийг буцаан авахаар Сангийн яамнаас авлага үүсгэн бүртгэсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт боловсрол, шинжлэх ухааны салбарын дараах хөтөлбөр тусгагдсан байна. Үүнд:

- ✚ Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор бүтээн байгуулалт хийх;
- ✚ Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр шинжлэх ухааны парк, хүрээлэнгийн цогцолбор, уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгын ажлыг эхлүүлж, олон улсын стандартад нийцүүлнэ.
- ✚ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн орон нутаг дахь их сургуулиудыг хотхон хэлбэрт үе шаттай шилжүүлнэ.

Тайлант онд 31 сургууль, 63 цэцэрлэг, 22 дотуур байр, 12 сургуулийн спорт заал тус тус ашиглалтад оруулснаар сургуулийн хүүхэд хүлээн авах хүчин чадал 35,580 суудлаар, цэцэрлэгийн хүчин чадал 10,020 хүүхдийн орны тоогоор, 22 дотуур байр 1320 орны тоогоор тус тус нэмэгдэж, 142 барилга байгууламжид их засвар хийж, 270 барилга байгууламжийг улсын комисс хүлээн авсан байна.

Мөн ТЕЗ-ийн төсөвт батлагддаг боловч аймаг, нийслэлийн боловсролын үйлчилгээг дэмжих зорилготой дараах зардлыг бүрэн хянах боломжгүй нийт төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 76 хувийг эзэлдэг 1,320,868.4 сая төгрөгийн зардал байна. Үүнд:

- ✚ Ерөнхий боловсрол болон сургуулийн өмнөх боловсролд олгосон тусгай зориулалтын шилжүүлэг 1,150,219.7 сая;
- ✚ Аймаг, нийслэлд эрх шилжүүлсэн, хөрөнгө оруулалт 170,648.7 сая төгрөг;

Засгийн газрын урсгал шилжүүлэг буюу орон нутагт боловсролын үйлчилгээг хүргэхээр аймаг, нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулан тусгай зориулалтын шилжүүлэг 1,150,228.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Үүнээс тайлант онд Ковид-19 цар тахлын улмаас удаа дараа хөл хорио тогтоож цахимаар хичээллэсэнтэй холбоотой ЕБС-ийн үдийн цай, СӨБ-ын хоолны зардлын хэмнэлт 64,248.9 сая төгрөгийг ТЕЗ-ийн тусгай дансанд төвлөрүүлж, ЗГ-ын холбогдох тогтоолуудаар 43,739.9 сая төгрөгийг зарцуулж, 20,509.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд:

- ✚ Нийгмийн халамж хөтөлбөрийн хүрээнд 3 сарын хугацаанд давхардсан тоогоор 3,492.1 мянган хүүхдэд сар бүр 10.0 мянган төгрөг олгоход 34,922.0 сая;
- ✚ Эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөрийн хүрээнд Монгол-Японы эмнэлгийн дутагдаж буй эх үүсвэрт 8,000.0 сая;
- ✚ Хөл хориотой үед төрийн өмчийн 15, төрийн бус өмчийн 36 их, дээд сургуулиудын дотуур байранд амьдардаг 10,541 оюутны хоол, хүнс, ариутгалын зардалд 500.0 сая;
- ✚ Ковид-19-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн бэлэн байдлын зэрэг, өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн теле болон цахим хичээлийн зардалд 317.9 сая төгрөг.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд боловсрол ШУ-ны салбарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 6 хөтөлбөрийн сургуулийн өмнөх боловсролын-5, тусгай хэрэгцээт боловсролын-1, ерөнхий боловсролын-7, насан туршийн болон албан бус боловсролын-1, дээд боловсролын-4, шинжлэх ухаан, технологи-3 нийт 21 хөтөлбөрийн хэрэгжилт 77.8 хувьтай байна.

Тайлант онд ТЕЗ-ийн хэрэгжүүлэх тус хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал болон хөрөнгийн зардалд нийт 1,738,055.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,563,248.6 сая төгрөгийг зарцуулж 89.9 хувийн биелэлттэй байна.

Хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийн биелэлт түүнийг хэрэгжүүлэхээр баталсан төсвийн гүйцэтгэлийн биелэлт 12.2 хувиар зөрүүтэй байгаа нь салбарын хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг төсөв санхүү эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад төсвийн төсөлтэй хамт боловсруулан хүргүүлдэг боловч төсвийг өөрчлөн баталдаг, төсвийн тодотголоор хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлаагүйгээс шалтгаалсан байна.

3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 161 байгууллага, нэгж байршуулах мэдээллээс 18,325 мэдээллийг хугацаанд нь, 3,648 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1,982 мэдээллийг байршуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Харьяа байгууллагууд Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 246 мэдээллийг хугацаа хоцроож, 191 мэдээллийг байршуулаагүй /БШУЯ, БЗС, Боловсролын үнэлгээний төв, Шинжлэх ухаан, технологийн сан, Цөмийн физик судалгааны хүрээлэн, Дулаан техник, үйлдвэрлэл экологийн хүрээлэн, Ургамал газар тариалангийн хүрээлэн, Анагаах ухааны хүрээлэн, Уул уурхайн хүрээлэн, Шинжлэх ухааны академи, Математик тоон технологи, Палеонтологи, Биологи, Хэл зохиол, Одон орон геофизик, Физик технологи, Хими, хими технологи, Олон улсын харилцаа, Түүх угсаатны зүй, Археологи, Геологи, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн/

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагч болон харьяа байгууллагуудад 70.2 сая төгрөгийн 16 төлбөрийн акт, 93,707.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 31 албан шаардлага, 59,024.4 сая төгрөгийн 159 зөвлөмж хүргүүлснээс биелэлт 89.8 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	16	70.2	14	61.9	(2.0)	(8.3)	87.5
Албан шаардлага	31	93,707.2	26	82,930.9	(5.0)	(10,776.3)	83.9
Зөвлөмж	159	59,024.4	145	53,003.9	(14.0)	(6,020.5)	91.2
Нийт дүн	206	152,801.8	185	135,996.7	(21.0)	(16,805.1)	89.8

Өмнөх зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйд харьяа 7 байгууллагуудын аудитаар 1,032.9 сая төгрөгийн 3 албан шаардлага, 7 зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

- ✚ БШУЯ-ны аудитаар 86.7 сая төгрөгийн албан шаардлага;
- ✚ БЗС-ийн аудитаар 832.5 сая төгрөгийн 2 албан шаардлага;
- ✚ Ховд аймгийн боловсролын газар 86.7 сая төгрөг албан шаардлага;
- ✚ Соёл урлагийн их сургууль 44.2 сая төгрөгийн албан шаардлага;
- ✚ Монгол тэмүүлэл олон улсын хөтөлбөрийн сургалттай сургууль 20.5 сая төгрөгийн албан шаардлага;
- ✚ Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл ТӨҮГ;
- ✚ Монгол Улсын Боловсролын Их Сургууль;

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх, цалин хөлсний тушаал шийдвэр гэх мэт төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах.

ШУТС орон тооны баталсан бүтцээр 3 хэлтсийн нийт 24 орон тооноос санхүү, төлөвлөлтийн хэлтсийн 7 ажилтан нь нийт ажилтнуудын 30 хувийг эзэлж байгаа ба сангийн орон тоо, бүтцийг оновчгүй, харьяа 3 хүрээлэн нь батлагдсан орон тоог 26-аар хэтрүүлэн ажилласан, ШУА-ийн ерөнхийлөгчийн тушаалаар хүрээлэнгүүдийн захирлын үндсэн цалинг 1.2 сая төгрөгөөр тогтоож Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоос сарын үндсэн цалинг 0.2 сая төгрөгөөр илүү олгосон.

Засгийн газрын 2020 оны 111 дүгээр тогтоолоор байгуулагдсан Боловсрол мэдээллийн төв УТҮГ-ын бүтэц орон тоог баталсан сайдын 2020 оны А/222 дугаар тушаалыг Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг дараагийн аудитаар үргэлжлүүлэн үзэх шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 99 тайлан нэгтгэснээс 96 тайлан аудитад хамрагдаж, Зөрчилгүй 60, Хязгаарлалттай 12, Сөрөг 1, түүвэрт хамрагдсан 23, итгэл үзүүлсэн 3 тайлан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт авсан дараах байгууллагууд байна. Үүнд:

- ✚ Физик технологийн хүрээлэн
- ✚ Биологийн хүрээлэн
- ✚ Палеонтологийн хүрээлэн
- ✚ МАА-н эрдэм шинжилгээний хүрээлэн
- ✚ Уул уурхайн хүрээлэн
- ✚ Цөмийн физикийн судалгааны төв
- ✚ Шинжлэх ухаан, технологийн сан
- ✚ ЕБ-ын 29 дүгээр тусгай сургууль
- ✚ Багшийн хөгжлийн институт
- ✚ Монгол тэмүүлэл ЕБ-ын сургууль
- ✚ Өвөрхангай аймгийн Боловсрол, соёлын
- ✚ Налайх дүүргийн Боловсрол, соёлын газар

Мөн Ерөнхий боловсролын 116 дугаар сургууль Сөрөг дүгнэлт авсан байна.

4.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 46,186.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 39,554.2 сая төгрөгийн 140 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй нийт 6,632.3 сая төгрөгийн алдаа, зөрчлөөс 142.2 сая төгрөгийн зөрчилд 37 төлбөрийн акт тогтоож, 2,730.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 103 албан шаардлага хүргүүлж, 3,759.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 187 зөвлөмж өгсөн байна.

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 118,506.6 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 103,594.5 сая төгрөгийн алдааг залруулж, 4,677.6 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 7,417.9 сая төгрөгийн 9 албан шаардлага хүргүүлж, 2,816.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын залруулагдаагүй нийт 21,544.4 сая төгрөгөөс 1,925.6 сая төгрөгийн төлбөрийн актыг завсрын аудитаар тогтоосон тул нийт залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 19,618.8 сая төгрөг байна.

Залруулсан алдаа

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 103,594.5 сая төгрөгийн дараах 20 алдааг залруулав. Үүнд:

- ✚ Харьяа 32 байгууллага ТЕЗ-аас шилжүүлэн өгсөн 2,655.9 сая төгрөгийн хөрөнгө, бараа материалыг үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор;
- ✚ ТЕЗ болон харьяа байгууллагууд шилжүүлэн өгсөн, авсан хөрөнгө материалыг 5,155.1 сая төгрөгөөр дутуу, 230.8 сая төгрөгөөр илүү устгаж санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг илүү илэрхийлсэн;
- ✚ Харьяа 11 байгууллага элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 4 хөрөнгийг данснаас хасахдаа дахин үнэлгээний нэмэгдэл дансыг 1,151.7 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт дансыг 163.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн;
- ✚ Харьяа 11 байгууллага элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 4,655.9 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, дахин үнэлэн дансанд тусгахдаа 1,877.3 сая төгрөгөөр үнэ төлбөргүй орлогыг дутуу, дахин үнэлгээний нэмэгдэл дансыг илүү тайлагнаж, хөрөнгийн тодруулга тайланд 4,655.9 сая төгрөгөөр акталсан хөрөнгийг дутуу, дахин үнэлгээний хорогдол дансыг илүү илэрхийлсэн;

- ✚ Харьяа байгууллага хооронд балансаас баланст шилжүүлж авахдаа ЗГХО дансыг 406.0 сая бууруулсан, шилжүүлэн авсан 75.4 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 51.9 сая төгрөгөөр бусад ангиллаар тайлагнасан;
- ✚ Сурах бичиг эргэлтийн номын үлдэгдэл нөөц 72.9 сая төгрөгийг бараа материал дансанд тайлагнаагүй;
- ✚ Авлагаар бүртгэх 102.4 сая төгрөг бараа материал дансанд бүртгэлтэй;
- ✚ Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлж хэрэгжүүлсэн 74,715.2 сая төгрөгийн 2 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүгийн тайланд бүртгээгүй;
- ✚ Харьяа 41 байгууллага ТЕЗ-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээнээс шилжүүлэн өгсөн 4,187.3 сая төгрөгийн хөрөнгө, бараа материалыг тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан, хандив, бусад гэх мэт ангилалд тайлагнасан;
- ✚ Математик, тоон технологийн хүрээлэн үндсэн хөрөнгийн тодруулга тайланд нэмэгдсэн хасагдсан хөрөнгийг 134.1 сая төгрөгийг илүү илэрхийлсэн;
- ✚ Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль 1,044.0 сая төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх бараа материалыг данснаас хасахдаа тайлант хугацаанд зарцуулсан ангилалд бүртгэж, үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан зардлаар, хандиваар авсан 69.1 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд бусад ангилалд тайлагнасан;
- ✚ Цөмийн физикийн судалгааны төв нь дахин үнэлсэн 42.3 сая хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд шилжүүлсэн авсан хөрөнгөөр тайлагнасан;
- ✚ Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль гадаадын хандивын хөрөнгийг тодруулга тайланд бусад ангилалд тайлагнасан байна.
- ✚ Харьяа 2 байгууллага НДШ-ийн хөнгөлөлтийг и-тайланд 106.6 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор тайлагнасан;
- ✚ ХААИС төслийн урьдчилж гарсан зардал 886.1 сая төгрөгийг авлагаар бүртгэсэн;
- ✚ Сургалтын төлбөрийн авлагаа Дорнод их сургууль 587.5 сая, Улаанбаатар их сургууль 462.7 сая төгрөг хувь хүнээс авах авлагаар, АШУҮС 693.4 сая төгрөгийг зээлийн авлагаар бүртгэсэн;
- ✚ Боловсролын мэдээллийн технологийн төв УТҮГ Дээд боловсролын шинэчлэлийн төслөөс шилжүүлэн авсан 2,932.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй;
- ✚ Харьяа байгууллагуудын зам гүүрний барилга байгууламжийн дансанд монгол гэр, контейнер, хаалга, навчит мод, гэрийн буурь, цэвэр бохир усны шугам гэх мэт 651.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна.

Төлбөрийн акт

1. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн барилгын төслийн санхүүжилтэд 2018 онд улсын төсвөөс Монголын талын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн зарцуулаагүй үлдэгдэл 1,925.6 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн харилцах дансанд байршуулсан.

Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитаар төлбөрийн акт тогтоосон.

2. Ашиглалтад 2016-2018 онд орсон барилга байгууламжийн ажлын 37 аж ахуйн нэгж байгууллагад олгох 179.8 сая төгрөгийн барьцаа чөлөөлөх хугацаа дууссан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

3. Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолыг үндэслэн 2019 оны эцэст барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 2,572.2 сая төгрөгийн хэрэгжээгүй 20 хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт барьцаа хөрөнгийн дансанд байршиж байна. Тус үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч шийдэгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл", Засгийн газрын 2019 оны "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар авах зарим арга хэмжээний тухай" 430 дугаар тогтоолын 1.2-т "банкны баталгааг үндэслэн олгосон санхүүжилт болон барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2020 оны 7 дугаар сарын 30-ны дотор Сангийн яамны зөвшөөрлөөр чөлөөлөх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Албан шаардлага

1. Барьцаа хөрөнгийн дансанд Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолыг үндэслэн байршуулсан хэрэгжээгүй 12 хөрөнгө оруулалтын ажлын 2,902.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй;
Тус тогтоолын дагуу 4 хөрөнгө оруулалтын ажлын 2,320.2 сая төгрөгийг Чингис Хаан банкны баталгаагаар үндэслэн олгосон боловч, хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй баталгааг гаргаж авах боломжгүй болсон;
2020 оны 253 дугаар тогтоолыг үндэслэн хэрэгжээгүй 4 хөрөнгө оруулалтын ажлын 1,162.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулан төсвийн гүйцэтгэлийн тайланд гүйцэтгэлээр тайлагнасан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.8-д "хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах"; Засгийн газрын 2019 оны "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар авах зарим арга хэмжээний тухай" 430 дугаар тогтоолын 1.2-т "банкны баталгааг үндэслэн олгосон санхүүжилт болон барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2020 оны 7 дугаар сарын 30-ны дотор СЯ-ны зөвшөөрлөөр чөлөөлөх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгө дансанд 2015-2019 онуудад үүссэн, ашиглалтад орсон боловч ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, улсын төсвийн санхүүжилт зогссон, гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ биелүүлээгүй, шүүхийн маргаантай гэх мэт 137,869.5 сая төгрөгийн 107 дуусаагүй хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.8-д "хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах"; Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 8.1-д "Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 2.2.1-д заасан журмыг баримтлан төсвийн төсөлд тусгах төслийг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтална", 8.1.1-д "шилжих буюу хэрэгжүүлж буй төсөл", 15.5-т "...төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна", 16.5-д "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу шийдвэрлэнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3. Хөтөлбөр арга хэмжээний зардлаас буцалтгүй тусламж, шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговор, яамны гэрээт ажилтнуудын цалин, ахмадын арга хэмжээ, гадаад томилолтын зардалд нийт 200.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах арга хэмжээний тухай” 114 дүгээр тогтоолын 3.4-т “Төсвийн урсгал зардлаас дараах зардлыг санхүүжүүлэхийг хориглоно”, Сангийн сайдын 2014 оны Төсвийн эдийн засгийн ангилал батлах тухай 5, 2015 оны 55 дугаар тушаалаар баталсан журмын 6 дугаар хавсралт “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4. Төрийн өмчит их сургуулиуд нь Улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн статустай, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн өмчит үйлдвэрийн газар ангилалд нэгтгэгдэж, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тоо мэдээлэлд төрийн өмчит үйлдвэрийн газрын ангилалд ангилагдаж байгаа боловч санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Төсөвт байгууллагад мөрдөх санхүүгийн тайлангийн маягтаар тайлагнаж байна. Санхүүгийн тайлагналаа төсөвт байгууллагын батлагдсан маягтаар гаргаж байгаа бол Төрийн өмчит их сургуулиуд нь өөрийн орлогыг төсөвт тусган батлуулж, орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулахаар байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.3-т “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө”, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34-т “төсвийн байгууллага” гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг”; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

5. ХАА-н техникийн ШУТУ-ийн нэгдэл ТӨҮГ нь 2019-2020 онд үйл ажиллагаа явуулаагүй, эрх үүрэг тодорхойгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг /цаашид “захирал” гэх/ томилохдоо гэрээ байгуулна”, 19.1.2-т “Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин”, 20 дугаар зүйлийн 20.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

6. Дотоодын их дээд сургуульд хөнгөлөлттэй зээлээр 1995-2003 онд магистрын хөтөлбөрт суралцсан 95 төгсөгчийн 45.0 сая, 2004-2007 онд бакалаврын хөтөлбөрт суралцсан 3,128 төгсөгчийн 3,530.5 сая нийт 3,575.5 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй; Мөн 2008-2020 онд хөнгөлөлттэй зээлээр бакалавр, магистрын хөтөлбөрт суралцсан 11,267 төгсөгчийн 13,168.6 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй, зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.

Энэ нь Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь заалт, Засгийн газрын 2020 оны “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 70 дугаар тогтоолын 3.4-т “Сургалтын төлбөрийн зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох асуудлыг Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.8-д заасны дагуу Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу зохицуулна” гэсэн заалтууд тус тус хэрэгжихгүй байна;

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

7. Гадаад орны дээд боловсролын байгууллагын бакалавр магистр, докторын хөтөлбөрт суралцаж байгаа суралцагчдад олгох сургалтын төлбөр, амьжиргааны зардлын зээлийн хэмжээг тогтоогоогүй, өмнөх оны завсрын аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журмын 1.5-д “Тухайн жилд дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутны тоог Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн оны 3 дугаар сард багтаан батална”, Дээд боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай 2020 оны 70 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн зээл олгох журмын 2.1-д “Сургалтын төлбөрийн зээлийн хэмжээг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн, тухайн улсын амьжиргааны түвшинтэй харьцуулсны үндсэн дээр Засгийн газар жил бүр ялгавартайгаар тогтооно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

8. Тухайн жилд дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутны тоог БШУС-ын 2020 оны А/263 тоот тушаалаар 2020-2021 оны хичээлийн жилээс Дэлхийн шилдэг их сургуульд суралцах оюутны тоог 40 хүртэл баталсан байхад сайдын А/155 тушаалаар хяналтын тооноос илүү, сонгон шалгаруулалтгүй 19 суралцагчид 832.5 сая төгрөг олгож өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна..

Энэ нь Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журмын 1.5-д “Тухайн жилд дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутны тоог Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн оны 3 дугаар сард багтаан батална” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

9. Шинжлэх ухаан, технологийн сангаас төслийн санхүүжилт авсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, шинжлэх ухааны байгууллага, харьяа хүрээлэн, их сургуулиудын хэрэгжүүлсэн 12,640.5 сая төгрөгийн 211 төслийн хугацаа 2016-2019 онд дууссан боловч төслийн үр дүнг үнэлээгүй, гүйцэтгэгч нь захиалагч болон санхүүжүүлэгчид төслийн болон санхүүгийн тайланг хүлээлгэж өгөөгүй байна.

79	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх 203 төрлийн мэдээллээс хугацаа хоцорч мэдээлсэн 44 мэдээлэл байна.	1		Говь-Алтай БСУГ	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нягтлан бодогч	Т.Эрхэмбаяр, Г.Эрдэнэбаяр
80	Тус байгууллагад шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговортой холбоотой 22,937.5 мянган төгрөгийн авлага барагдаагүй үлдэгдэлтэй байна.	1				
81	Сумдын сургууль цэцэрлэгүүдэд 434000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн санхүүжилт олгоходоо худалдан авах ажиллагааны журам мөрдөөгүй	1	434.0	Өвөрхангай БСУГ	Дарга, Нягтлан бодогч	Ж.Пүрэвсүрэн, М.Отгон
82	Урсгал зардлын санхүүжилтээс 7000.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн	1	7.0			
83	Шатахуун илүү зарцуулсан 0.4 сая төгрөг байна.	1	0.4	Хэнтий БСУГ	Дарга, Нягтлан бодогч	С.Мөнхцэцэг, Г.Тунгалаг
84	2.1 сая төгрөгийн бараа материал тоолоогүй	1	2.1			
85	Үндсэн үйл ажиллагааны шимтгэлийн зардлаас гэрээт ажилтны шимтгэл төлсөн 0.3 сая, хөдөөгийн багш нарын спортын наадамд 1.0 сая төгрөгийг хувь хүний дансанд шилжүүлсэн.	1	1.3			
86	Хичээлийн шинэ жилд түрээсийн сурах бичгийн тооцоог авч үзэхэд 80.8 сая төгрөг төвлөрөхөөс 67.6 сая төгрөг төвлөрч, 13.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.	1	13.1	Баянхонгор БСУГ	Дарга, Нягтлан бодогч	Ц.Энхтөр, Л.Оюунтуяа
87	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын гүйлгээ, санхүүгийн тайлан хагас жилээр дутуу мэдээлсэн /7 удаагийн зарлагын гүйлгээ /	1		Говьсүмбэр БСУГ	Дарга, Нягтлан бодогч	А.Зургаанжин, Н.Одонтуяа
88	Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баримтжуулаагүй, батлагдсан маягтаар баталгаажуулаагүй,	1				
89	Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос хувь хүний орлогын албан татвар 1,232.0 мянган төгрөгийг суутган авсан байна.	1	1.2	Дорнод БСУГ	Дарга	А.Нансалмаа
90	Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс 45 мэдээллийн хугацааг хоцроож, нийт 20 мэдээллийг байршуулаагүй байна.	1				
91	Томилолтын зардлаас анхан шатны баримтын бүрдэлгүй 307.2 мянган төгрөгийг гаргасан байна.	1	0.3			
92	Санхүүгийн тайланд тусгасан авлагын 58.2 мянга, өглөгийн 360.0 мянга, нийт 418.2 мянган төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	0.4			
93	2020.07.10-нд томилогдсон эд хариуцагчид нярвын ажлыг хүлээлгэж өгөөгүй. Хөрөнгө эзгүйдсэн	1		Дундговь БСУГ	Дарга, Нягтлан бодогч	А.Мөнхтуяа, Д.Эрдэнэ-Оюун
94	Хагас жилийн хөрөнгийн тооллогын чанаргүй хийсэн. Албан хаагчдын хөрөнгийн бүртгэлийг 2019 оны 6 дугаар сараас хойш хийгээгүй.	1				
95	Албан хаагчидтай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ хийгээгүй	1				
96	Шатахууны тооцоо хийгээгүй.	1	2.1			
97	Хугацаа дууссан гэрээг үндэслэн худалдан авалт хийсэн	1	1.7			
98	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч өөртөө тушаал гарган үр дүнгийн урамшуулал авсан.	1	1.2			
99	Үр дүнгийн тайлангийн цалингийн зардал, анхан шатны баримт болон мөнгөн	1	3.1			

Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	гүйлгээний тайлангийн цалингийн зардлаас зөрүүтэй байна.						
100	Байгууллагын удирдлага солигдоход хөрөнгийг бүрэн хүлээлцээгүй, зөөврийн компьютер бодитоор байхгүй байхад тооллогод оруулан тооцсон байна.	1					
101	Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс хугацаа хоцроосон 5 мэдээлэл, огт оруулаагүй 1 мэдээлэл байна.	1					
102	Тайлант хугацаанд 1,297.7 мянган төгрөгийн авлага, 1,297.7 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Өглөг, авлагын үлдэгдэлтэй гарсан байна.	1	1.3	Орхон БСУГ	Дарга,, Нягтлан бодогч	О.Ариунгэрэлт М.Халиунаа	
103	Шатахууны зарцуулалтыг түүвэрлэн тулган баталгаажуулахад 1,753.6 мянган төгрөгийн шатахууны норм хэтрүүлэн зарцуулсан байна.	1	1.8				
104	Биеийн тамирын боловсролын мэргэжилтэнд илүү орон тоо дээр ажил хавсарсны нэмэгдэл олгосон байна.	1					
105	Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 2,810.0 төгрөгийн сэлбэг хэрэгсэл, тавилгын зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	2.8	Өмнөговь БСУГ	Дарга, Нягтлан бодогч	Ц.Оюунчимэг, С.Тунгалаг	
106	Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг тулган баталгаажуулахад 126,923.1 төгрөгийн гүйлгээ мэдээлээгүй байна.	1	127.0				
107	Үндсэн хөрөнгийн тайланд 84,247.9 төгрөгийн үлдэх өртөггүй тавилга, тоног төхөөрөмж, санхүүгийн программ, тээврийн хэрэгсэл тусгагдсан байна.	1	84.2				
108	Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 2 албан хаагчид цалин давхардуулан олгосон	1	0.8	Сэлэнгэ БСУГ	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Ч.Жаргалсайхан, Ц.Цэцэгмаа	
109	Өмнөх оны тайлангаар өгөгдсөн БШУ-ны яамнаас болон бусад хөрөнгө оруулалтаар өгсөн хөрөнгийн тооцоо нийлж, баталгаажуулах гэж өгөгдсөн хөрөнгийн орлогыг баримтаар баталгаажуулах зөвлөмж хэрэгжүүлээгүй байна.	1	86.7	Ховд БСУГ	Дарга, Нягтлан бодогч, мэргэжилтэн	М.Пүрэвхүү Б.Уугантуяа Д.Нямдорж	
110	Тус байгууллагад ажиллаж байгаад халагдсан хүн шүүхийн шийдвэрээр ажиллагаагүй үеийн нөхөн төлбөрийг олгосон	1	4.6	Нийслэлийн БСУГ	Дарга, Нягтлан бодогч	Ж.Гантулга, Д.Наранхүү	
111	Бараа бүтээгдэхүүн худалдан авах гэрээний тусгай нөхцөлд заасан гүйцэтгэлийн баталгаа, барьцааг байршуулаагүй байхад 142,941.2 мянган төгрөгийн бараа нийлүүлэх гэрээ хийж, урьдчилгаа төлбөр төлсөн.	1	5.5				
112	Тайлант онд цалингийн орлогоос нийгмийн даатгалын шимтгэл, татварыг суутгаж тайлагнаагүй, гарт олгох цалинг илүү олгосон, авлага үүсгээгүй цалин, бараа материал, нийгмийн даатгалын шимтгэл, татварыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэж тайлагнасан.	1	0.7	Чингэлтэй дүүрэг БУСХ	Дарга, Нягтлан бодогч	Ш.Оюунсүрэн, Ж.Мөнхбаяр	
113	Төсвийн шууд захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заагдсан хугацаанаас 24 хоногоор хоцроон ирүүлсэн. Санхүүгийн үйл ажиллагааны нотлох баримт материалыг ирүүлээгүй.	1					
114	Шилэн дансны цахим зарим сарын төсвийн гүйцэтгэл, орлого, зарлагын 6 мэдээ (64,780.5 мянган төгрөг) гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан, 4 мэдээг огт мэдээлээгүй;	1		Налайх дүүрэг БСУХ	Дарга, Нягтлан бодогч	Д.Отгонжаргал О.Батзаяа	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 11 дугаар сарын 05

№ 01/107

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны яамны 2020 оны санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн барилгын төслийн санхүүжилтэд 2018 онд улсын төсвөөс Монгол талын хөрөнгө 2,759,500,000 төгрөгийн санхүүжилтийг ТЕЗ-ийн хөрөнгө оруулалтын дансанд шилжүүлж 2019 онд 833,864,325 төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон байна. Тус хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтэд 2019-2020 онд төсөв батлагдаагүй бөгөөд зарцуулаагүй санхүүжилт 1,925,635,675 төгрөгийг 2018 оноос хойш барьцаа хөрөнгийн харилцах дансанд байршуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл;" гэж заасныг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

Хөрөнгө оруулалтын ажлын барьцаа хөрөнгийн харилцах дансанд байршиж байгаа 1,925,635,675 төгрөгийг "Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлого"-ын 100900000601 тоот дансанд 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор төвлөрүүлэх;

Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, зүгээр төлөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэлдэхүүн хэргүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчийн сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2020\1103SAG1.Docx

001090331

Биелэлтийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар, Хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Энх-Амгалан, Ерөнхий нягтлан бодогч Х.Ганцэцэг нарт даалгав.

ТОГТООСОН:


САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

 Б.СЭРЖМЯДАГ

АУДИТОР

 Ч.ДАШДАВАА

АКТЫГ:

ЗӨВШӨӨРСӨН:


БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

 Д.БАТБААТАР

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА

 Ч.ЭНХ-АМГАЛАН

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

 Х.ГАНЦЭЦЭГ

Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т Энэ хуулийн 16 дугаар зүйлээс заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан түүшаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 04 дугаар сарын 26

№ 116/АО110001

Улаанбаатар хот

СЯГ-0021/23/СТА-ТЭЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолыг үндэслэн 2019 оны эцэст барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 2,572,174,156.00 төгрөгийн хэрэгжээгүй 20 хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт барьцаа хөрөнгийн дансанд байршиж байна. Тус үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч шийдэгдээгүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл", Засгийн газрын 2019 оны "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар авах зарим арга хэмжээний тухай" 430 дугаар тогтоолын 1.2-т "банкны баталгааг үндэслэн олгосон санхүүжилт болон барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2020 оны 7 дугаар сарын 30-ны дотор СЯ-ны зөвшөөрлөөр чөлөөлөх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Барьцаа хөрөнгийн дансанд байршиж байгаа 2,572,174,156.00 төгрөгийг улсын төсвийн орлогод тооцож Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10 -ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР


Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 04 дугаар сарын 26 № 117/А0110001
С.АТ- 2021/23/СТА-ТЭЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ашиглалтад 2016-2018 онд орсон барилга байгууламжийн ажлын 37 аж ахуйн нэгж байгууллагад олгох 179,799,988.10 төгрөгийн барьцаа чөлөөлөх хугацаа дууссан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Барьцаа хөрөнгийн дансанд байршиж байгаа 179,799,988.10 төгрөгийг улсын төсвийн орлогод тооцож Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2021\0426auditin 2-R Газар3.Docx

001090204



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 610/А0110001

Улаанбаатар хот

СМГ-2021/23/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинжлэх ухаан, технологийн сангаас төслийн санхүүжилт авсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, шинжлэх ухааны байгууллага, харьяа хүрээлэн, их сургуулиудын хэрэгжүүлсэн 12,640.5 сая төгрөгийн 211 төслийн хугацаа 2016-2019 онд дууссан боловч төслийн үр дүнг үнэлээгүй, гүйцэтгэгч нь захиалагч болон санхүүжүүлэгчид төслийн болон санхүүгийн тайланг хүлээлгэж өгөөгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2014 оны 301 дүгээр тогтоолоор баталсан “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”-ын 7.3-т “Төслийн гүйцэтгэлийн явц захиалагч, санхүүжүүлэгчээс үл хамаарах шалтгаанаар удаашрах, үр дүн нь гэрээнд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд захиалагч, санхүүжүүлэгч нь хугацаанаас өмнө гэрээг цуцлах, санхүүжүүлсэн хөрөнгийг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх талаар шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад санал тавьж шийдвэрлүүлнэ”, мөн журмын 8.4.1-д “захиалсан үр дүн, санхүүжилтийн талаар зохих журмын дагуу бичсэн төслийн тайланг захиалагч, санхүүжүүлэгчид тогтоосон хугацаанд нь хүлээлгэн өгөх”, 8.4.2-т “төслийн хүрээнд бий болсон шинжлэх ухааны шинэ мэдлэг (энэ журмын 8.2-т тусгагдсан баримтаар баталгаажсан)-ийн талаар улсын стандартын дагуу бичсэн эрдэм шинжилгээний ажлын тайланг итгэмжлэн хадгалагчид төсөл дууссанаас хойш 3 сарын дотор цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүлээлгэн өгөх” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төслийн гүйцэтгэлийн явц захиалагч, санхүүжүүлэгчээс үл хамаарах шалтгаанаар удааширсан, үр дүн нь гэрээнд заасан шаардлагыг хангаагүй төслийн гэрээг цуцлах, санхүүжүүлсэн хөрөнгийг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлэх;
2. Төслийн захиалагч, санхүүжүүлэгч нар гүйцэтгэгчээс төслийн үр дүнг үнэлж, төслийн болон санхүүгийн тайланг хүлээн авч, гэрээний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
3. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Шинжлэх, ухааны газрын дарга С.Мөнхбат, Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал М.Тунгалаг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264130

\\0.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0426auditin 3-R Gazar58.Docx

001081426



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26 № 611/А0110001
СЯТ-0001/23/СТА-ТЭЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тухайн жилд дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутны тоог БШУС-ын 2020 оны А/263 тоот тушаалаар 2020-2021 оны хичээлийн жилээс Дэлхийн шилдэг их сургуульд суралцах оюутны тоог 40 хүртэл баталсан байхад сайдын А/155 тушаалаар хяналтын тооноос илүү, сонгон шалгаруулалтгүй 19 суралцагчид 832.5 сая төгрөг олгож өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журмын 1.5-д "Тухайн жилд дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутны тоог Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн оны 3 дугаар сард багтаан батална" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тухайн онд баталсан хяналтын тооноос илүү, сонгон шалгаруулалтад оролцоогүй суралцагчид хууль, журам зөрчиж сургалтын төлбөрийн санхүүжилт олгохгүй байх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Дээд боловсролын газрын дарга С.Должин, Боловсролын зээлийн сангийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Ариунболд нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 612/А0110001

Улаанбаатар хот

САГ- 0001/23/СТА- 783

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ Үүнд:

Гадаад орны дээд боловсролын байгууллагын бакалавр магистр, докторын хөтөлбөрт суралцаж байгаа суралцагчдад олгох сургалтын төлбөр, амьжиргааны зардлын зээлийн хэмжээг тогтоогоогүй, өмнөх оны завсрын аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна

Энэ нь Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журмын 1.5-д "Тухайн жилд дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутны тоог Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн оны 3 дугаар сард багтаан батална", Дээд боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай 2020 оны 70 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн зээл олгох журмын 2.1-д "Сургалтын төлбөрийн зээлийн хэмжээг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн, тухайн улсын амьжиргааны түвшинтэй харьцуулсны үндсэн дээр Засгийн газар жил бүр ялгавартайгаар тогтооно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутны тоо болон гадаад орны дээд боловсролын байгууллагын бакалавр магистр, докторын хөтөлбөрт суралцаж байгаа суралцагчдад олгох сургалтын төлбөр, амьжиргааны зардлын зээлийн хэмжээг журамд заасан хугацаанд жил бүр шинэчлэн тогтоож байх,
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Дээд боловсролын газрын дарга С.Должин, Гадаад харилцаа хамтын ажиллагааны газрын дарга Д.Гарьд, Боловсролын зээлийн сангийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Ариунболд нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 613/20110001

Улаанбаатар хот

САГ- 2021/23/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгө дансанд 2015-2019 онуудад үүссэн, ашиглалтад орсон боловч ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, улсын төсвийн санхүүжилт зогссон, гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ биелүүлээгүй, шүүхийн маргаантай гэх мэт 137,869.5 сая төгрөгийн 107 дуусаагүй хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.8-д “хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах”; Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 8.1-д “Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 2.2.1-д заасан журмыг баримтлан төсвийн төсөлд тусгах төслийг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтална”, 8.1.1-д “шилжих буюу хэрэгжүүлж буй төсөл”, 15.5-т “...төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна”, 16.5-д “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу шийдвэрлэнэ” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улсын комиссын акт гарч ашиглалтад орсон, барилга байгууламжийн хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу шийдвэрлүүлэх;

2. Улсын төсвийн санхүүжилт зогссон, гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ биелүүлээгүй, шүүхийн маргаантай шалтгааны улмаас хэрэгжихгүй байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын дэлгэрэнгүй судалгаа гаргаж, асуудлыг холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлэх;
3. Хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналтай холбоотойгоор яамны газар, хэлтэс, албан тушаалтнуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн мэдээ, файлын сан үүсгэж аудитын хугацаанд шаардлагатай тоо, мэдээгээр хангаж байх, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газар ирүүлэх;
4. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн газрын дарга Ч.Энх-Амгалан нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26 № 614/АДИ/0001
СЯГ-2021/23/СТА-ТЭЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Дотоодын их дээд сургуульд хөнгөлөлттэй зээлээр 1995-2003 онд магистрын хөтөлбөрт суралцсан 95 төгсөгчийн 45.0 сая, 2004-2007 онд бакалаврын хөтөлбөрт суралцсан 3,128 төгсөгчийн 3,530.5 сая нийт 3,575.5 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй;
2. Мөн 2008-2020 онд хөнгөлөлттэй зээлээр бакалавр, магистрын хөтөлбөрт суралцсан 11,267 төгсөгчийн 13,168.6 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй, зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.

Энэ нь Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь заалт, Засгийн газрын 2020 оны “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 70 дугаар тогтоолын 3.4-т “Сургалтын төлбөрийн зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох асуудлыг Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.8-д заасны дагуу Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу зохицуулна” гэсэн заалтууд тус тус хэрэгжихгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зээлийн эргэн төлөх журамгүйгээс олон жил хуримтлагдсан 16,744.1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн авлагыг шийдвэрлэх хууль эрхзүйн орчныг тодорхой болгох;
2. Биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Гадаад харилцаа хамтын ажиллагааны газрын дарга Д.Гарьд, Дээд боловсролын газрын дарга С.Должин, Боловсролын зээлийн сангийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Ариунболд нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shoordlaga\2021\0426auditin 3-R Gazar55.Docx

001081417



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 615/АД/110001

Улаанбаатар хот

СЯТ- 2021/23/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ХАА-н техникийн ШУТУ-ийн нэгдэл ТӨҮГ нь 2019-2020 онд үйл ажиллагаа явуулаагүй, эрх үүрэг нь тодорхойгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг /цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна", 19.1.2-т "Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин", 20 дугаар зүйлийн 20.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Үйл ажиллагаа явуулдаггүй ХАА-н техникийн ШУТУ-ийн нэгдэл ТӨҮГ-ыг хууль, журамтай нийцүүлэн шийдвэрлэх;
2. Биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Шинжлэх ухааны газрын дарга С.Мөнхбат, Санхүү, эдийн засгийн газрын дарга С.Нансалмаа, ерөнхий нягтлан бодогч Х.Ганцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0426auditin 3-R_Gazar53.Docx

001081414



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26 № 616/АО110001
С.АТ-2021/23/СТА-ТЭЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Харьяа төрийн өмчит их, дээд сургуулиудын төсөв, бүртгэл тайлагнал, өмчийн хэлбэртэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

Төрийн өмчит их сургуулиуд нь Улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн статустай, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн өмчит үйлдвэрийн газар ангилалд нэгтгэгдэж, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тоо мэдээлэлд төрийн өмчит үйлдвэрийн газрын ангилалд ангилагдаж байгаа боловч санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Төсөвт байгууллагад мөрдөх санхүүгийн тайлангийн маягтаар тайлагнаж байна. Санхүүгийн тайлагналаа төсөвт байгууллагын батлагдсан маягтаар гаргаж байгаа бол Төрийн өмчит их сургуулиуд нь өөрийн орлогыг төсөвт тусган батлуулж, орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулахаар байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 4.1.3-т "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт", Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө", Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34-т "төсвийн байгууллага" гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг"; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн өмчит их сургуулиудын төсөв, санхүүгийн тайлагнал, байгууллагын өмчийн хэлбэрийг хууль, журамтай нийцүүлэн тодорхойлох;
2. Биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Дээд боловсролын газрын дарга С.Должин, Санхүү, эдийн засгийн газрын дарга С.Нансалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0426auditin 3-R Gazar52.Docx

001081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26 № 617/АУН10001
САГ-2021/23/СТА-ТЭЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөтөлбөр арга хэмжээний зардлаас буцалтгүй тусламж, шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговор, яамны гэрээт ажилтнуудын цалин, ахмадын арга хэмжээ, гадаад томилолтын зардалд нийт 200.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах арга хэмжээний тухай" 114 дүгээр тогтоолын 3.4-т "Төсвийн урсгал зардлаас дараах зардлыг санхүүжүүлэхийг хориглоно", Сангийн сайдын 2014 оны Төсвийн эдийн засгийн ангилал батлах тухай 5, 2015 оны 55 дугаар тушаалаар баталсан журмын 6 дугаар хавсралт "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөтөлбөр арга хэмжээний зардлаас зориулалт бус зарцуулалт гаргахгүй байх, холбогдох хууль, журмыг мөрдөн ажиллах, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар, Санхүү, эдийн засгийн газрын дарга С.Нансалмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ

001081408



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 дугаар сарын 26 № 618/А0110001
СЯ-2024/23/СЯ-ТЭЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Барьцаа хөрөнгийн дансанд Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолыг үндэслэн байршуулсан хэрэгжээгүй 12 хөрөнгө оруулалтын ажлын 2,902.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй;
2. Тус тогтоолын дагуу 4 хөрөнгө оруулалтын ажлын 2,320.2 сая төгрөгийг Чингис Хаан банкны баталгаагаар үндэслэн олгосон боловч, хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй баталгааг гаргаж авах боломжгүй болсон;
3. 2020 оны 253 дугаар тогтоолыг үндэслэн хэрэгжээгүй 4 хөрөнгө оруулалтын ажлын 1,162.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулан төсвийн гүйцэтгэлийн тайланд гүйцэтгэлээр тайлагнасан байна.

Эдгээр нь:

- Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.8-д "хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах"; Засгийн газрын 2019 оны "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар авах зарим арга хэмжээний тухай" 430 дугаар тогтоолын 1.2-т "банкны баталгааг үндэслэн олгосон санхүүжилт болон барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2020 оны 7 дугаар сарын 30-ны дотор СЯ-ны зөвшөөрлөөр чөлөөлөх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Банкны баталгааг гаргаж авах боломжгүй байгаа шалтгааны улмаас хэрэгжихгүй байгаа хөрөнгө оруулалтын ажлыг холбогдох албан тушаалтан байгууллагаар шийдвэрлүүлэх;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230


\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0426auditin 3-R Gazar50.Docx

001081405

2. Барьцаа хөрөнгийн дансанд байршиж байгаа хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэлээр санхүүжүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх;
3. Хөрөнгө оруулалтын ажлыг барьцаа хөрөнгийн дансанд байршуулахгүй байх, батлагдсан хөрөнгө оруулалтын ажлыг тухайн онд багтаан гүйцэтгэж, Төсвийн тухай хууль болон холбогдох хууль, журмыг мөрдөн ажиллах, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газар ирүүлэх;
4. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн газрын дарга Ч.Энх-Амгалан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ

ТЭМДЭГЛЭЛ

Series of horizontal dotted lines for writing.